

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ, СУМДЫН  
2021 ОНЫ 03 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2021.04.05

Сүхбаатар сум

**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:**

**Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчдийн үйл ажиллагааны талаар:**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 1 удаа хуралдаж 7 асуудал хэлэлцэж 8 тогтоол баталлаа. Үүнд:

1. Мал амьтны цахим бүртгэлийн систем, амьтны гаралтай бүтээгдэхүүнд ДМАЭМБ /ДХБ/ тавигдах шаардлагын тухай аймгийн Мал эмнэлгийн газрын дарга С.Ариунтөгсийн мэдээллийг сонслоо.

2. “Зөгийн аж ахуйд мөрдөх мал эмнэлэг, ариун цэвэр эрүүл ахуйн дүрэм” батлах тухай асуудлыг хэлэлцээд боловсруулалтын шатанд дахин буцаан хойшлуулав.

3. “Хөгжлийн шийдэл” ТББ-аас хийсэн “Цар тахлын улмаас үүссэн хүндрэл, бэрхшээлийг даван туулах арга замыг тодорхойлох судалгааны тайлан”-тай танилцан Сэлэнгэ аймагт үйл ажиллагаа эрхэлж буй арилжааны банкуудын удирдлагуудыг хүлээн авч уулзан “Ажлын байрыг дэмжих зээл”-ийн асуудлаар ярилцав.

4. Ой тэмдэглэх тухай асуудлыг хэлэлцээд Баянгол сумын үүсэн байгуулагдсаны 90 жилийн ойг 2021 оны 07 дугаар сарын 02-03-ны өдрүүдэд, Орхонтуул сумын үүсэн байгуулагдсаны 90 жилийн ойг 2021 оны 07 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд, Мандал сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн үүсэн байгуулагдсаны 70 жилийн ойг 2021 оны 10 дугаар сарын 12-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлэхийг тус тус зөвшөөрч, ойгоо угтаж хамт олны идэвх санаачилгыг өрнүүлэн тодорхой бүтээлч ажил зохион байгуулж ажиллахдаа /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлж халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөн ажиллахыг даалгалаа.

5. Шагналд уламжлах тухай асуудлыг хэлэлцээд Сүхбаатар сумын ахмад настан, чөлөөт уран бүтээлч Ёндонжамцын Балданг Соёлын гавьяат зүтгэлтэн цолоор, Ардын дуу бүжгийн Сэлэнгийн долгио чуулгын дуучин, дуу ангийн багш Жаргалын Дашдавааг Урлагийн гавьяат зүтгэлтэн цолоор, мөн чуулгын ахмад ажилтан, чөлөөт уран бүтээлч Басангийн Жаргалыг Гавьяат жүжигчин цолоор, Орхон сумын ахмад настан, Шинэ эхлэл группын зөвлөх инженер Тогоочийн Доржтовууг Хөдөө аж ахуйн гавьяат механикжуулагч цолоор, төрийн захиргаа, соёл урлаг, боловсрол, эрүүл мэнд, хууль хяналт, хил хамгаалах байгууллага, хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт олон жил үр бүтээлтэй ажилласан зарим хүмүүсийг төрийн одон, медалиар шагнуулахаар уламжиллаа. Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 11, Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор 1, Алтан гадас одонгоор 19, Цэргийн гавьяаны одонгоор 1, Хөдөлмөрийн хүндэт медалиар 49 хүнийг шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжиллаа.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Б.Нарантуяа болон Тэргүүлэгчид тус сарын 02, 03-ны өдрүүдэд Түшиг, Цагааннуур, Зүүнбүрэн, Шаамар суманд ажиллаж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан гаргасан тогтоол шийдвэрийн биелэлт улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалт, төсөл

хөтөлбөрүүдийн хүрээнд хийгдсэн бүтээн байгуулалтын ажилтай танилцах, зарим төр, төсвийн байгууллага болон иргэдтэй уулзаж санал хүсэлтийг нь сонслоо.

Мөн “Гацуурт” ХХК болон сумын иргэдийн хооронд үүсээд байгаа асуудлаар сумын болон компанийн удирдлагуудтай харилцан санал солилцож, Улаан овооны нүүрсний уурхайн үйл ажиллагаа, зарим малчин өрхүүдээр орж хаваржилтын байдалтай танилцлаа.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Тэргүүлэгчид аймгийн Мал эмнэлгийн газар болон Хөдөө аж ахуйн газруудын цаг үеийн ажил байдалтай танилцан, цаашид хэрэгжүүлэх бодлогын болоод чиг үүргийн төлөвлөгөөнүүдэд санал солилцон ажиллалаа.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, нийтийн албан тушаалтныг авлигын эсрэг соён гэгээрүүлэх, чадавхжуулах замаар авлигаас урьдчилан сэргийлэх “Авлигын мөн чанар, шалтгаан хор хөнөөл”, “Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн байгууллагын удирдах албан тушаалтны хүлээх үүрэг”, “Авлигын гэмт хэрэг-шинэ зохицуулалт” зэрэг сэдвээр сургалтыг цахимаар зохион байгуулж, сургалтад аймаг, сумын нийт 430 төлөөлөгч хамрагдаж авлигын эсрэг хууль, тогтоомжийн талаарх мэдлэг, чадвараа дээшлүүллээ.

#### **Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:**

Төрийн албаны Зөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь Салбар зөвлөл Төрийн албаны ерөнхий шалгалтыг 03-р сарын 12, 13-ны өдөр зохион байгуулж, шалгалтад нийт 328 иргэн бүртгүүлснээс 254 буюу 77.4 хувь нь хамрагдаж 80 шалгуулагч төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэгдэх боломжтой боллоо. Энэ удаагийн шалгалт цар тахлын үед Улсын Онцгой комисс, Эрүүл мэндийн яамны зөвлөмж чиглэлийн хүрээнд аюулгүй байдлыг ханган халдвар хамгааллын дэглэмийг чанад барьж анх удаа шалгуулагчдыг хурууны хээгээр баталгаажуулан, бүрэн цахимжилтын хүрээнд зохион байгуулагдсанаараа онцлог байлаа. Шалгалтыг Төрийн албаны зөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Улсын бүртгэлийн хэлтэс, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Тагнуулын газар хамтран зохион байгууллаа.

Засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоол “Коронавируст халдвар (Ковид-19) цар тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ын дагуу аймгийн хэмжээнд төр, төсвийн байгууллагын албан хаагчдийн 10-30 хувь нь ажиллаж байна.

Төрийн албаны зөвлөл, Канадын МЕРИТ төслөөс хамтран “Хувь хүний хөгжил”-ийн чиглэлээр 2021 оны 03 дугаар сард цахим хэлбэрээр зохион байгуулсан “Сэтгэл хөдлөлөө удирдах нь”, “Албан хаагчдын идэвхи оролцоог нэмэгдүүлэх нь”, “Харилцан хүндэтгэл, итгэлцэл бүхий орчныг бүрдүүлэх нь”, “Өөрчлөлтөд дасан зохицож удирдах нь” сэдвийн хүрээнд явагдсан цуврал сургалтад аймаг, сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, мэргэжилтнүүд болон аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, албадын холбогдох мэргэжилтнүүдийг хамрууллаа. Сургалтад давхардсан тоогоор 660 гаруй төрийн албан хаагчид хамрагдлаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас Монгол Улсад Орчин цагийн Зэвсэгт хүчин үүссэн байгуулагдсаны 100 жилийн ойг тохиолдуулан Хүүхэд, залуучуудад Монгол Улсын Зэвсэгт хүчний түүхэн замнал, баатарлаг үйлсийг судалж, танин мэдэх хүсэл эрмэлзлийг төрүүлэх, тэдний авьяас чадварыг нээн хөгжүүлэх, шилдэг бүтээлүүдийг алдаршуулах олон нийтэд сурталчлах, хүүхэд залуучуудад цэрэг-эх оронч хүмүүжил төлөвшүүлэх, иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх зорилгоор “Монгол Улсын Зэвсэгт хүчин 100” гар зургийн уралдааныг 4 насны ангилалд цахимаар

зохион байгуулж 23 сургуулийн 120 гаруй бүтээлээс бага, дунд, ахлах ангийн сурагчдын дундаас 40 зураг шалгарч II үе шат буюу Улсын уралдаанд Сэлэнгэ аймгийн ерөнхий боловсролын лаборатори IV сургуулийн 126 ангийн сурагч Х.Номин-Эрдэнэ тусгай байрт шалгарлаа.

Мөн Монгол цэргийн нэгдсэн холбоо, “Отгонтэнгэр” Их сургуулиас хамтран зохион байгуулсан “Эрхмийн дээд Монгол эр хүн” сэдэвт эссэ бичлэгийн уралдаанд Сэлэнгэ аймгийн Мандал сумын Түнхэл тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 12а ангийн сурагч Б.Эрхэм-Эрдэнэ 210 хүүхдээс тэргүүлж 1 дүгээр байрт шалгарлаа.

Монгол Улсын сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны 03 дугаар сарын 29-ний “Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо байгуулах тухай” 40 дүгээр тогтоолын дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах Сэлэнгэ аймгийн Сонгуулийн хороог 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулаад байна.

#### **Аймгийн Онцгой комиссын үйл ажиллагааны талаар:**

Аймгийн Онцгой комиссоос дэлхий дахинд тархаад буй коронавируст халдвар /COVID-19/-ын тохиолдол гарч, халдварлах эрсдэл бий болсонтой холбоотойгоор урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах чиглэлээр дараах ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Улсын Онцгой комиссын хуралдааны тэмдэглэл, тогтоол, тушаал, Монгол Улсын Шадар сайд, Эрүүл мэндийн сайд, Онцгой байдлын ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга нарын баталсан тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд Аймгийн Онцгой комисс 18 удаа хуралдан 51 асуудлыг хэлэлцэж 88 асуудлыг шийдвэрлэн аймгийн Засаг даргын захирамж 1, тогтоол 5, хурлын тэмдэглэл 18 гаргасан. Мөн Гамшгаас хамгаалах хууль тогтоомж болон Засгийн газар, Улсын Онцгой комиссоос өгсөн үүрэг чиглэл, аймгийн Онцгой комиссын хуралдаанаас гарсан шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд сум, агентлаг, байгууллагуудад нийт 87 албан тоотоор үүрэг чиглэл, зөвлөмж, шаардлага, хүсэлтийг хүргүүлж, 249 албан бичгийн бүртгэл хөтлөн хүлээн авч, албан бичгээр ирсэн тайлан мэдээг боловсруулан нэгтгэж өдөр тутмын нөхцөл байдлын мэдээнд тусгуулах, ирүүлсэн хүсэлтүүдийг холбогдох ажлын хэсэгт хүргэн шийдвэрлүүлэн, аймгийн хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин ажиллаж байна.

Шуурхай штабын 70363684 дугаарын утсанд 963 мэдээлэл, цахим хаягаар 867, албан бичиг, гар өргөдөл 33 нийт 1863 мэдээлийг хүлээн авч шийдвэрлэсэн байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим хуудас болон Онцгой байдлын газрын цахим пэйж хуудсанд 119 удаа мэдээ, мэдээлэл байршуулж 174945 хандалтыг авсан байна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран 2021 оны 03 сарын 01-ний өдрөөс эхлэн өдөрт 2 удаагийн давтамжтайгаар 12:00,17:00 цагуудад нөхцөл байдлын талаарх мэдээлэл бэлтгэн аймгийн Засаг даргын Тамгын газраас “Сэлэнгэ аймаг АЗДТГ”, “Сэлэнгэ Цахим телевиз” цахим хуудас, “Зиндаа.мн” сайт, “Улс төрч.мн” сайт, Сүхбаатар сум дахь лед дэлгэц, орон нутгийн “Миний Монгол ТВ”, “Таны Сэлэнгэ ТВ” мөн МҮОНТ-ийн ММ агентлаг, “Өлзий” телевиз, “Монцамэ” агентлаг зэрэг мэдээллийн сувгуудаар мэдээ, мэдээллийг дамжуулан. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Улсын Онцгой комиссын шуурхай штаб, Онцгой байдлын ерөнхий газарт тухай бүр мэдээлэл хүргүүлэн ажиллаж байна.

2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар манай аймагт 14 батлагдсан тохиолдлыг аймгийн Нэгдсэн эмнэлгийн Ковид эмчилгээний тасагт /доторын тасагт/

тусгаарлан 4 эмч эмнэлгийн ажилтан, халдвартын тасагт Алтанбулаг боомтоор орж ирсэн 3 иргэн, ойрын хавьтлийн 1 иргэнийг ажиглалт тусгаарлалтад авч 2 эмч эмнэлгийн ажилтан ажиллаж байна.

2021 оны 03 дугаар сарын 22-ноос 4 зам болон, Номгон тосгоны постон дээр 24 цагаар Улаанбаатар болон халдвар бүртгэгдсэн бүсээс ПГУ-н шинжилгээгүй ирж байгаа Сэлэнгэ аймгийн иргэдээс түргэвчилсэн шинжилгээ авах цэгийг байршуулсан. Энэ цэгийг байгуулснаар 2 эерэг тохиолдлыг илрүүлж, шуурхай хариу арга хэмжээг хурдан зохион байгуулж халдварын голомтыг түргэн хугацаанд хумьж чадлаа.

Аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан хариу арга хэмжээний баг Эрүүл мэндийн газрын сургалтын зааланд байрлаж тандал судалгааг хийн ажиллаж байна. Тандалт судалгаагаар Сүхбаатар, Түшиг суманд гарсан эерэг тохиолдлын нийт 288 орын хавьтал 466 дам хавьтлийг илрүүлж холбогдох арга хэмжээг авч ажиллалаа.

Сүхбаатар суманд Дархан-Уул аймгийн 2 эерэг гарсан тохиолдлын ойрын болон дам хавьтлийн 307 иргэнийг 95 хувьтай шинжилгээнд хамруулж, холбогдох арга хэмжээг шуурхай авч ажилласан. Тухайн иргэдийн үйлчлүүлсэн 15 газрыг олж ариутгал халдваргүйтгэлийг бүрэн хийлгэсэн.

Түшиг суманд 2021 оны 03 дугаар сарын 30-нд эмнэлгийн ажилчнаас Коронавируст халдвар /КОВИД-19/ илэрч, Эрүүл мэндийн газраас түргэвчилсэн оношлуурын 2 баг гарч ойрын хавьтлийн 89 хүнээс түргэвчилсэн оношлогоог хийж үүнээс 3 эерэг тохиолдол гарч баталгаажуулах шинжилгээгээр баталгаажсан. ПГУ-ийн шинжилгээг 24 хүнээс авч 1 иргэн батлагдсан. 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдөр Эрүүл мэндийн газраас томилогдсон сум тосгоны эмч ажилчдаас бүрдсэн 10 баг Түшиг сумын нийт иргэдээс түргэвчилсэн оношлуураар шинжилгээ хийж 22 эерэг тохиолдол гарсан байна.

Коронавируст халдварыг илрүүлэх түргэвчилсэн болон ПГУ-ийн шинжилгээнд нийт 11295 иргэн хамрагдсанаас 14 эерэг тохиолдлыг илрүүлсэн GENEXPERT-ийн баталгаажуулах шинжилгээнд 5 хүний сорьцийг авч 2 эерэг тохиолдол гарсан байна.

Уг хугацаанд нийт 35 иргэнийг тусгаарлах байрны хамгаалалтад авч давхардсан тоогоор 990 хоног 30 хяналтын цэгт 7410 тээврийн хэрэгсэлтэй Цагдаагийн газрын албан хаагч 120 тээврийн хэрэгсэлтэй, Онцгой байдлын газрын 320 алба хаагч, Эрүүл мэнд, эмнэлгийн байгууллагын 480, Мэргэжлийн хяналтын газрын 110 бусад төрийн байгууллагуудтай хамтран нийт 1030 албан хаагч үүрэг гүйцэтгэсэн.

Улсын Онцгой комиссын тогтоол, шийдвэрийн дагуу Монгол Улсын хилээр нийт 6 орны 1844 зорчигч, 8 орны 1679 тээврийн хэрэгслийг зохих журмын дагуу шалган нэвтрүүлсэн.

Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын даргын баталсан 2020 оны 01/05 дугаартай удирдамжийн дагуу аймгийн хэмжээнд 03 дугаар сарын 03-31-ний өдрийн хугацаанд хүнсний худалдааны 70, хоол үйлдвэрлэлийн 18, хүнсний үйлдвэр цех 3 нийт 91 объект хамрагдсан. Гүйцэтгэлийн хяналт шалгалтад 18 объект хамрагдсан.

Шалгалтын явцад хүнсний аюулгүй байдалтай холбоотой 127 зөрчлийг илрүүлж, үүнээс газар дээр нь 75 зөрчлийг арилгуулж, зөрчил дутагдлыг арилгуулах талаар улсын байцаагч нарын хамтарсан 52 заалттай 4 албан шаардлагыг хугацаатай өгч биелэлтийг тооцоход албан шаардлагын биелэлт 50.4 хувьтай хангагдаж байна.

Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар дуусах хугацаа хэтэрсэн 46 нэр төрлийн 274 ширхэг 1346.1 мянган төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг хураах акт үйлдэж хураан авч эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хураан авсан эд зүйл хэрэгслийг үнэлэх, худалдан борлуулах устгах талаар шийдвэр гаргах хэрэгжилтэд хяналт тавих орон

тооны бус зөвлөлд шилжүүлж, 6.0 сая төгрөгийн шийтгэлийн арга хэмжээг авч бүрэн барагдуулсан.

Хяналт шалгалтын явцад аймгийн Мэргэжлийн хяналтын газрын итгэмжлэгдсэн лабораторийн эрүүл ахуйн нян судлалын болон химийн лабораторид 56 аж ахуйн нэгж, байгууллагаас 6 нэр төрлийн 56 дээж авч итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээнд хамруулахад шинжилгээний дүнгээр 4 дээж шаардлага хангасан, 25 дээж шаардлага хангаагүй үзүүлэлттэй гарч, 27 дээжийн хариу гараагүй байна. Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн улсын байцаагчийн 30 дүгнэлтийг гаргаж хүргүүлсэн байна.

Хяналт шалгалтын явцад хоол үйлдвэрлэлийн ажлын байрны өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээнд хэрэглэж буй халдваргүйжүүлэлтийн уусмалын концентрацыг газар дээр нь түргэвчилсэн тестээр тодорхойлж ажиллалаа.

Зөрчлийн арга хэмжээг ангилж үзвэл:

- Цагдаагийн газраас нийт 4 гомдол мэдээллийг хүлээн авч шалгаснаас 4 аж ахуйн нэгжийг 500.0 төгрөг нийт 2.000.0 төгрөгөөр;
- Онцгой байдлын газар нийт 13 гомдол мэдээллийг хүлээн авч 19 иргэнийг 100.0 төгрөгөөр нийт 1.900.0 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны “Бүх нийтийн ариутгал халдваргүйжүүлэлтийг эрчимжүүлэх тухай” А/15 тоот захирамж, аймгийн Онцгой комиссын 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 476 дугаар албан тоотын хэрэгжилтэд 03 дугаар сарын 25-26-ны өдрүүдэд Мэргэжлийн хяналтын газрын 12 улсын байцаагч, 6 сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч, Цагааннуур сумын худалдаа үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, сумдын багийн Засаг дарга нар хяналт тавьж, зөвлөгөө зөвлөмж өгч ажиллалаа.

Аймгийн хэмжээнд 03 дугаар сарын 25-26-ны өдрүүдэд нийтийн эзэмшлийн зам талбайд 43 объектод 79568 м<sup>2</sup>, байрны орц, гадна орчны 41 объектод 108851 м<sup>2</sup>, хүнсний худалдаа, үйлчилгээний 237 объектод 40240 м<sup>2</sup>, 99 төрийн байгууллагын 160910 м<sup>2</sup>, худалдаа, үйлчилгээний 168 объектод 18320 м<sup>2</sup> талбайд, нийт **588 объектод 407889 м<sup>2</sup>** талбайд ариутгал халдваргүйтгэл хийж ажилласан.

#### **Онцгой байдлын ажил үйлчилгээний талаар:**

Улсын Онцгой комиссын даргын 2021 оны “Түр журам батлах тухай” 18 дугаар, “Түр журам, заавар батлах тухай” 20 дугаар, “Түр журам батлах тухай” 21 дүгээр, “Шуурхай штабыг шинэчлэн байгуулах тухай” 22 дугаар тушаалууд, “Ажлын хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 778 дугаар албан бичиг, Эрүүл мэндийн сайдын 2021 оны “Түр заавар шинэчлэн батлах тухай” А/29 дүгээр тушаалуудыг сумдын Онцгой комиссын дарга нарт хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллах талаар үүрэг, чиглэл өгч ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны “Журам батлах тухай” 339, 340 дүгээр тогтоол, 2017 оны “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөртэй болох тухай” 67 дугаар тогтоолуудын хэрэгжилтийг хангах, иргэд олон нийтийн гамшгаас урьдчилан сэргийлэх гамшгийн үед өөрийгөө болон бусдыг авран хамгаалах мэдлэг олгох дадлага сургуулийн хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулаа.

- Орон нутгийн хэмжээнд ашиглагдаж байгаа зарлан мэдээллийн дохио дамжуулах хэрэгслийн судалгааг гаргасан.
- Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга, хурандаа Б.Ууганбаярын Монголын үндэсний олон нийтийн телевизээр нэвтрүүлсэн “Газар хөдлөлтийн үед бэлэн

байдлаа хангадаг хариуцлагатай иргэн бэлтгэх нь” сэдэвт теле хичээл, гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэх, нүүлгэн шилжүүлэх дадлага сургууль зохион байгуулах, бэлэн байдлаа хангах, зарлан мэдээллийн дохиогоор ажиллах аргачлал, зөвлөмж бичлэг, шторкыг Сүхбаатар сумын “Миний Монгол” телевиз, “Таны Сэлэнгэ” телевиз, Мандал сумын “Мандал”, “Миний Монгол”, Сайхан сумын “Эрдэнэ” телевиз, электрон самбар ашиглан олон удаагийн давтамжтайгаар иргэдэд мэдээлэл, зөвлөмж хүргэлээ.

- Аймгийн хэмжээнд гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийг 14 сумдын сирень дохио болон хөдөлгөөнт дуут дохио ашиглан хүргэсэн бол аймгийн төвд “МЦХ” ХК, “Алтан тариа” ХХК, Онцгой байдлын газраас суурин хэлбэрээр, мөн алслагдсан баг хорооны айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудад Онцгой байдлын газрын гал унтраах үндсэн албаны 2 автомашин, Эрэн хайх аврах зориулалтын 2 автомашины дуут дохиог дуугарган зарлан мэдээллийн дохиог иргэдэд хүргэлээ.

### **Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуульд:**

Аймгийн 17 суманд үйл ажиллагаа явуулж буй 78 төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагын нийт 1000 ажилтан албан хаагчид, иргэн тус тус хамрагдлаа

Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан “**Эм ханган нийлүүлэх байгууллагын барилга байгууламж**”-д Гамшгаас хамгаалах болон Галын аюулгүй байдлын тухай хууль, норм нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 15 объектод зохион байгуулж 64 зөрчил илрүүлэн гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлагыг 8 аж ахуйн нэгж, байгууллагад, албан мэдэгдэл 4 тус тус хүргүүлж, зөрчил дутагдлыг арилгуулан ажиллалаа.

Тус сард объектын гал түймрийн 5, аврах ажиллагааны 1 дуудлага ирж тухай бүр богино хугацаанд хор уршгийг арилган ажилласан.

### **Мэргэжлийн хяналтын үйл ажиллагааны талаар:**

Аймгийн хэмжээнд 03 дугаар сарын байдлаар голомтын халдваргүйжүүлэлтийг 1175 объектод 642569.5 м2 талбайд Мандал сумын нэгдсэн эмнэлэг, Зооноз өвчин судлалын төв, урьдчилан сэргийлэх зорилгоор нийтийн эзэмшлийн зам талбайд 212720 м2 талбайд Онцгой байдлын газар, байрны орц, хонгил, гадна талбайд 190918.5 м2 талбайд Зооноз өвчин судлалын төв, Мал эмнэлгийн газар, хүнсний худалдааны газруудад 134260 м2 талбайд Мал эмнэлгийн газрын халдваргүйтгэлийн баг халдваргүйжүүлэлтийг хийж, аймгийн хэмжээнд голомтын болон урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлтийг 1180468 м2 талбайд хийхэд Мэргэжлийн хяналтын газраас хяналт тавьж ажиллалаа. Мөн 5 объектод 1018 м2 талбайд голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийг Мандал сум дахь Нэгдсэн эмнэлгийн халдваргүйтгэлийн баг хийхэд хяналт тавьж ажиллалаа.

Сүхбаатар сумын “Сэлэнгэ хөгжил тохижилт” ОНӨААТҮГ-ын харьяа “Олон улсын худалдааны төв”-ийн үйл ажиллагаанд тавигдах тусгай нөхцөл, шаардлага, халдвар хамгааллын дэглэмийн мөрдөлтийн хэрэгжилтэд болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөрчил дутагдлыг таслан зогсоох зорилгоор худалдааны төвийн лангуу, павильон түрээслэгч иргэдийн үйл ажиллагаатай танилцаж зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж, 6 зөрчил илэрч 1 буюу 16 хувийг газар дээр нь арилгуулж, коронавируст халдвар /Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэм сахиулах

талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн 13 заалт бүхий зөвлөмж өгч ажиллалаа.

Дархан-Уул аймгаас Сайхан сумын чиглэлд түгээлт хийж буй 3 аж ахуйн нэгжийн тээвэрлэлтийн горим, хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал, шилжүүлэн ачих үеийн халдвар хамгааллын дэглэмд хяналт тавьж ажиллахад “Тансаг болор” ХХК-ий түгээлт хийж буй тамхи, тамхин бүтээгдэхүүн баталгаажилтгүй, “Дэлгэрэх хүнс” ХХК-ий 3 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнд үйлдвэрлэсэн он, сар, өдөр бичигдээгүй түгээлт хийж байсныг буцааж ажилласан.

Хүдэр суманд мод бэлтгэлийн аж ахуйн нэгжид Байгаль орчин, Цагдаагийн байгууллагатай хамтарсан хяналт шалгалтыг 14 хоног, мөн Баруунбүрэн сумын мод бэлтгэлтийн аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийж нийтдээ 15.500.0 төгрөгийн торгуулийн арга хэмжээг авч бүрэн барагдуулан ажилласан.

#### **Стандартчилал, хэмжил зүйн үйл ажиллагааны талаар:**

Ерөө сумын 2-р багт байрлах “Илбү” ХХК-ий “Ноёт” халтар арвайн гурилын цехийн үйлдвэрлэсэн 1 нэрийн 1 бүтээгдэхүүнийг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын итгэмжлэгдсэн сорилтын лабораторид сорилт шинжилгээнд оруулж бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ олгов. Сүхбаатар сумын 3-р багт байрлах “Гүнжийн булан” цехийн утсан загас, Сүхбаатар сумын 7-р багт байрлах “Залуу Сэлэнгэ” ХХК-ий үйлдвэрлэж буй хүнсний бүтээгдэхүүнд аймгийн Мэргэжлийн хяналтын газрын итгэмжлэгдсэн сорилтын лабораторид сорилт шинжилгээнд хамруулан шинжээчийн дүгнэлт гарган ажиллалаа.

Сүхбаатар, Шаамар, Баянгол, Хүдэр, Цагааннуур сумын 17 аж ахуйн нэгжийн 17 үйлчилгээний газарт тохирлын үнэлгээ хийж, МУ-ын “Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ, ерөнхий шаардлага MNS5021-1:2019” стандартын шаардлага хангасан 10 үйлчилгээний газарт тохирлын гэрчилгээ олгосон байна.

Стандарт, мэдээллийн салбар сангаас 5 аж ахуй нэгж, байгууллага иргэний захиалгын дагуу 96 нэрийн 96 стандартаар мэдээлэл, арга зүйн зөвлөмж өгч, 2 нэрийн 2 стандарт борлуулж, 26400 төгрөгийн орлого бүрдүүлж ажиллалаа. Дотоод албан хэрэгцээнд 8 нэрийн 8 стандартыг хэвлэн олгосон.

Эзлэхүүн хэмжлийн төрлөөр: Шаамар, Цагааннуур, Зүүнбүрэн сумын 3 шатахуун түгээх станцын 10 шатахуун түгээгүүр шалган баталгаажуулав. Аж ахуйн нэгж, байгууллагын 13 усны тоолуур шалгаснаас 1 тоолуур ашиглалтын шаардлага хангахгүй тул мэдэгдэл өгч 12 усны тоолуурт баталгаажуулалтын гэрчилгээ олгов.

“Сод Монгол” ШТС-ын шатахуун түгээгүүрийн 4 шингэн хэмжигчид ээлжит баталгаажуулалт, Сүхбаатар сумын 1 ШТС-ын 2 шингэн хэмжигчийг шалгаж, баталгаажуулалт хийсэн.

“Хөтөл МТЧ” ШТС-ын дуудлагын дагуу Аи-92 түгээгүүрт ээлжит бус шалгалт хийж, дуудлага хүсэлтийг цаг хугацаанд нь гүйцэтгэлээ.

Шалгалт тохируулгаар: Мэргэжлийн хяналтын газар, Ус, цаг уур орчны шинжилгээний албаны сорилт шинжилгээний лабораторийн 6 электрон жин, 7 туухайд шалгалт тохируулга хийсэн.

Хэмжих хэрэгсэл баталгаажуулалтын 2021 оны гэрээг 3 байгууллагатай байгуулсан.

Механикийн хэмжлийн төрлөөр: Сүхбаатар суманд худалдаа үйлчилгээ, эмнэлэг, иргэдийн 69 жин, 2 туухай, Сант сумын эрүүл мэндийн төвийн 1 термометр шалган баталгаажууллаа.

Даралтын хэмжлийн төрлөөр: Автоклавын манометр 3 ш, цусны даралтын аппарат 12 ширхэгийг шалган баталгаажууллаа.

Цахилгаан хэмжлийн төрлөөр: 3 фазын 100 вольтын 78 ш, 1 фазын 6 ш тоолуур баталгаажууллаа.

**Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:**

Өнгөрсөн сард 689 баримтаар 7,593,478.7 мянган төгрөгийн төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог хянан гүйцэтгэлээ.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр аймгийн цахим хуудас, шилэн данс болон ил тод самбарт байршуулж, аймгийн төсвийн гүйцэтгэлийн 02 дугаар сарын нэгдсэн мэдээг гаргаж Статистикийн хэлтэст хүргүүлж, 02 дугаар сарын аймгийн орлогыг татварын хэлтэстэй тулган баталгаажуулж мэдээг авч хамтарч ажилласан.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтийг тус тус тавьсан.

**1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:**

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
<b>1. Орон нутгийн төсвийн нийт орлого</b>		<b>19,022,979.1</b>	<b>18,542,657.5</b>	<b>97.5</b>
1.1	<b>Орон нутгийн төсвийн орлого</b>	<b>4,108,807.9</b>	<b>5,191,831.6</b>	<b>126.4</b>
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	2,821,364.6	2,461,736.6	87.3
	Сумдын төсвийн орлого	1,287,443.3	2,730,095.0	212.1
1.2	Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	807,723.8	807,723.8	100.0
1.3	Улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг	8,613,869.7	8,613,869.7	100.0
1.4	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг	109,392.8	38,190.4	34.9
1.5	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/	264,281.9	131,938.3	-
1.6	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/	2,962,742.5	2,962,742.5	100.0
1.7	Төсөвт байгууллагын өөрийн орлого	796,243.1	796,243.1	100.0
1.8	ОНХС-д хандив	951,666.7		-
1.8	Сум хөгжүүлэх сан /орлого/	408,250.7	118.0	-
<b>2. Орон нутгийн төсвийн нийт зарлага</b>		<b>19,022,979.1</b>	<b>12,085,852.2</b>	<b>63.5</b>
2.1	<b>Орон нутгийн төсвийн нийт зарлага</b>	<b>19,022,979.1</b>	<b>12,085,852.2</b>	<b>63.5</b>
	Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага	4,641,185.8	2,151,363.2	46.4
	Сумдын орон нутгийн хөгжлийн сан	687,575.3	24,621.8	3.6
	Сумдын сум хөгжүүлэх сан			
	<b>Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага</b>	<b>3,244,020.2</b>	<b>1,354,629.9</b>	<b>41.8</b>
	Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт	162,250.0		
	Аймгийн замын сангийн хөрөнгө оруулалт			
	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	1,192,391.6		
	Халамжийн сан	19,200.0	12,000.0	62.5
	Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага	<b>1,270,178.6</b>	<b>1,010,167.3</b>	<b>79.5</b>
	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө	600,000.0	332,462.6	55.4
	Сумдын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	10,244,072.1	8,416,897.8	82.2
	Аймгийн тусгай зориулалтын	206,125.7	138,339.5	67.1



	шилжүүлгийн байгууллагуудын зарлага			
<b>3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг</b>		<b>11,198,517.9</b>	<b>10,810,394.3</b>	<b>96.5</b>
3.1	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	2,320,366.3	2,064,586.3	89.0
3.2	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	23,557.0	23,557.0	-
	Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд	23,557.0	23,557.0	-
	Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд			
	Хөрөнгө оруулалтын зардалд			
3.3	Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	240,724.9	108,381.3	
	Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд	240,724.9	108,381.3	
	Усны татаас			
	Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд			
3.4	Сумдад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	8,430,682.9	8,430,682.9	100.0
3.5	Аймагт олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	183,186.8	183,186.8	100.0
3.6	Тусгай зориулалтын шилжүүлэг /салбараар/	8,613,869.7	8,613,869.7	100.0
	- Ерөнхий боловсролын сургууль	4,579,269.1	4,579,269.1	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	2,270,818.8	2,270,818.8	100.0
	- Эрүүл мэндийн байгууллага	1,554,808.8	1,554,808.8	100.0
	- Газрын кадастрын байгууллага	113,314.0	113,314.0	100.0
	- Хүүхдийн байгууллага	95,659.0	95,659.0	100.0
<b>4. Тусгай сангуудын зарлага</b>		<b>408,250.7</b>	<b>118.0</b>	<b>-</b>
4.1	Сумдын сум хөгжүүлэх сан	408,250.7	118.0	-

## 2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл		2020 02- сар	2021 02- сар	2021-02 2020-02 Х/төгрөгөөр/
<b>1.ХҮНСНИЙ БАРАА</b>				
<b>1</b>	<b>ТАЛХ, ГУРИЛ, БУДАА</b>			
	Гурил /савласан, кг/	1 200	1 316	109.7
	Талх /орон нутгийн, ш/	1 233	1 266	102.7
	Нарийн боов /кг/	2 466	2 533	102.7
	Будаа /кг/	2 333	2 633	112.9
	Элсэн чихэр /кг/	2 066	2 466	119.4
<b>2</b>	<b>МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН</b>			
	Хонины мах /кг/	7 833	8 500	108.5
	Үхрийн мах /кг/	9 333	9 600	102.9
	Адууны мах /кг/	7250	8 000	110.3
	Ямааны мах /кг/	7833	7 000	89.4
	Дотор мах, цувдай /цусгүй/	4000	4 000	100.0
	Хиам /чанасан, кг/	10 333	10 666	103.2
<b>3</b>	<b>СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ</b>			
	Сүү /задгай, л/	1 800	1 900	105.6

	Сүү / савласан, л/	3 000	3133	104.4
	Тараг /задгай, л/	2 000	2 100	105.0
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	15 500	15 500	100.0
	Айраг /л/	4 500	5 000	111.1
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	8 650	8 650	100.0
	Өндөг /ш/	350	533	152.3
<b>4</b>	<b>БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС</b>			
	Ургамлын тос /л/	4 500	6 200	137.8
	Өөхөн тос /кг/	2 500	2 500	100.0
	Шар тос /кг/	15 000	15 000	100.0
	Масло /задгай, кг/	4 166	4 166	100.0
<b>5</b>	<b>ХҮНСНИЙ НОГОО</b>			
	Төмс /кг/	1 000	1 000	100.0
	Лууван /кг/	1166	1 433	122.9
	Манжин /кг/	1666	1600	96.0
	Байцаа /кг/	1200	1500	125.0
	Сонгино /кг/	1866	2833	151.8
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	4 566	4 566	100.0
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	3000	3 016	100.5
<b>7</b>	<b>ШАТАХУУН</b>			
	Бензин А - 80	1 750	1 400	80.0
	Бензин А - 92	1 840	1 470	79.9
	Дизелийн түлш	2 470	2 090	84.6

#### **Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:**

Цахим эрх зүйн хөтчийн мэдээллийн булангаар иргэдэд сар бүр, эрх зүйн анхан шатны зөвлөгөө, мэдээллийг хүргэн ажиллаж, хуваарийн дагуу иргэд болон захиргааны албан хаагч нийт 320 иргэнд сургалт, сурталчилгааны ажлыг тахимаар болон цахимаар зохион байгуулж, ажиллалаа.

Мөн коронавируст /COVID-19/ халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын Тамгын газраас фэйсбүүк хуудас, selenge.gov.mn, E-KHutuch.mn сайтад “Зөрчлийн тухай хууль”-иар 10 удаа, “Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-иар 5 удаа, шторкийг 7 удаагийн давтамжтайгаар байршуулан мэдээлэл хүргэн ажилласан.

**Цагдаагийн газар:** Аймгийн хэмжээнд 2021 оны 02 дугаар сард 5 холбогдогчтой 17.5 сая төгрөгийн хохиролтой 46 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 15 хэргээр буюу 24.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн илрүүлэлт 2.6 хувьтай байгаа нь өмнө оныхоос 3.3 хувиар буурсан байна.

#### **Улсын бүртгэлийн хэлтэс:**

- Төрсний бүртгэл – 148 /эрэгтэй-71, эмэгтэй-77/
- Гэрлэлтийн бүртгэл – 30
- Гэрлэлт цуцалсны бүртгэл – 7
- Үрчлэлт - 7
- Эцэг тогтоолт – 4
- Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл – 5
- Нас баралт – 40
- Нийт олгосон иргэний үнэмлэх – 484
- Шинээр олгосон иргэний үнэмлэх – 218
- Дахин олгосон иргэний үнэмлэх – 219

- Иргэний үнэмлэхний хугацаа дуусч солиулсан – 258
- Гадаад паспорт олголт – 26
- Аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн – 130
- Хот доторх шилжилт хөдөлгөөн – 220 тус тус бүртгэгдсэн байна.

Хөмрөг үүсгэгч байгууллагуудын ирүүлсэн мэдээллийг архивын баримтын тоо бүртгэлийн нэгдсэн системд мэдээлэл оруулах ажил хийгдэж байна.

Төрийн архивын 2021 оны нягтлан шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аймгийн Ардын хянан шалгах хороо /хуучнаар/-ны 1961-1984 оны 209 баримтад нягтлан шалгалт хийсэн байгаа бөгөөд энэ ажлын хүрээнд тус хөмрөгийн дансны ХН-ийн бүртгэлийг шинэчлэх, устгах бичгийн жагсаалт үйлдэх зэрэг ажлууд хийгдэж байна.

Хушаат сумын ЗДТГ-ын хөмрөгийн шинэчилсэн дансны бүртгэл, шилжүүлэх хүснэгт, устгах хэргийн жагсаалтыг гаргаж ББНШАЗК-ын хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болгосон.

Архивын цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын төлөвлөгөөг 5 өдрөөр гаргаж гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан.

Баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд Хушаат сумын ЗДТГ-ын хөмрөгийн 17 ХН-д ЭШТБ ажлыг хийж, 2410 хуудас баримтыг скайнердан мастер хувь үүсгэсэн.

Зам засвар арчлалтын “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК, Хушаат сумын ЗДТГ, Баруунхараа дахь зам засвар арчлалтын “Хараа” ХХК-ий нийт 33 ХН-ийн 5129 хуудас баримтын агуулгыг уншиж заалт 3998, хүний нэр 18603, газарзүй нэр 3306, байгууллагын нэр 2113 шивж эх баримттай холбох ажлыг хийж гүйцэтгэлээ.

Баянгол сумын 90 жилийн ойн арга хэмжээний түүхэн ном бичихэд зориулж 01,02,14,32 дугаар хөмрөгүүдээс 1960-1968 оны 25 хадгаламжийн нэгжийг судалгаа, шинжилгээний ажилд ашиглуулж, архивын баримтыг хуулбарлан өгөв.

Иргэдийн хүсэлтийн дагуу архивын баримтын цахим болон мастер хувь, цаасан суурьтай баримтаас нийт 251 хуулбар, магадлагаа тодорхойлолт 50 гаргаж тус тус үйлчилсэн.

### **Дөрөв. Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:**

#### **1. Боловсрол, соёл урлаг, спортын талаар:**

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/58 тоот тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл, сургалтын үйл ажиллагааг танхимаар зохион байгуулах түр журам”-ын дагуу сургууль, цэцэрлэгийн орчинд коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлийг хүргүүлж, 03 дугаар сарын 01-ний өдрөөс танхимын сургалтын үйл ажиллагааг эхлүүлж, цэцэрлэгийн хүүхдийн 64.0 хувь, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын 92.6 хувь нь танхимын сургалтад хамрагдаж, Сүхбаатар сумын 7 сургууль, 7 цэцэрлэг дээр очиж, түр журмын хэрэгжилт, тулгамдаж байгаа асуудлуудын талаар үзэж танилцаад хэрэгжүүлэх зөвлөмжүүдийг өгч ажилласан.

УИХ-ын гишүүн Ч.Ундрам, Elab Education Академитай хамтран математик, физик, хими, нийгмийн ухаан, англи хэл, монгол хэлний хичээлээр элсэлтийн ерөнхий шалгалт өгөх хүүхдүүдэд зориулж онлайн сургалт явуулахад дэмжлэг үзүүлэн хамтарч ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 12-р ангийг 1167 сурагч төгсөх ба математик, физик, химийн хичээлээр 951 суралцагч урьдчилсан байдлаар элсэлтийн ерөнхий шалгалт өгөх санал өгснийг Glassroom-ын 6 ангид хуваарилан бүртгүүлж, цахим хичээлд хамруулж байна.

Математик, Англи хэлний “Бяцхан туслагч” номыг Сүхбаатар сумын 100 сурагчид үнэ төлбөргүй олголоо.

Монгол хэл бичгийн цахим шалгалтыг 03 дугаар сарын 12-ны өдөр 999 сурагч, 03 дугаар сарын 19-ний өдөр 414 сурагчийг хамруулан зохион байгуулж, шалгалтын дүнг сургууль, багш нарт хүргүүлэн, сайжруулах арга зүйн зөвлөмж өгч ажиллаж байна.

Боловсрол, шинжлэх ухааны яамнаас хэрэгжүүлж буй “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээнд Мандал сумын 2, Баянгол 3, Сүхбаатар сумын 6 дугаар сургуулиуд сонгогдон, хөтөлбөрийн 4 дэх шатны төслийн хэрэгжилтэд үнэлгээ хийгдэхээр Боловсрол, шинжлэх ухааны яамнаас хамтран ажиллаж байна.

Дэлхийн усны өдрийг тохиолдуулан “Усны үнэлэмж, үнэ цэнэ” мэдээлэл түгээх үйл ажиллагааг аймгийн нийтийн аж ахуйн “Урсгал ус” ХХК-тай хамтран зохион байгуулж, “Ус бидний амьдралд”, “Дэлхийн усны өдөрт”, “Дэлхийн усны нөөц” шторкуудыг 35 сургуулийн 17210 сурагчдад цахим хэлбэрээр хүргэж сурталчиллаа.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/118 тоот тушаалаар батлагдсан “Хүүхдийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм”-ийн 3.6 дахь заалт, мөн сайдын 2021 оны А/58 тоот “Түр журам батлах тухай” тушаалын 3.3 дахь заалт хүүхдийн эрүүл мэндийн үзлэг, шинжилгээг өрхийн эмнэлэг, эрүүл мэндийн төвтэй хамтран зохион байгуулж ажиллах чиглэл ирүүлсний дагуу Эрүүл мэндийн газартай хамтран Сүхбаатар сумын 1226 хүүхдийг хамруулан зохион байгуулсан.

Мэргэжлийн бүлгийн ажлын хүрээнд цэцэрлэгийн арга зүйч багш нартай онлайн уулзалтыг 7 хоног бүр зохион байгуулан, хийж хэрэгжүүлэх ажил болон хийсэн ажлаа дүгнэн ярилцаж, хичээл үйл ажиллагаанд тулгамдаж байгаа асуудлаа тодорхойлон, агуулгын болон хөгжлийн хоцрогдлыг богино хугацаанд арилгах, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан, 3 дугаар улирлын сургалтын төлөвлөгөөг бүлэг бүрээр нэгтгэн гаргаж бүх цэцэрлэгүүд хүргүүлэн ажиллаж байна.

Боловсрол, шинжлэх ухааны яамнаас зохион байгуулсан “Хүүхдийн хөгжлийн болон харилцааны онцлог, хүүхэдтэй ажиллах арга зүй, нийгэм, сэтгэл зүйн асуудал, шийдвэрлэх арга зам” сургалтад ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны 28 багшийг оролцууллаа.

Улсын хэмжээнд зохион байгуулагдсан уншлагын марафон “Reading Marathon-2021”-д унших, сонсох болзлыг хангасан сурагчдын тоогоор шилдэг 5 багшийн нэгт Сайхан сумын 2 дугаар сургуулийн багш Л.Энхцэцэг шалгарч, тус марафонд оролцсон 356 багийн 711 сурагчаас хамгийн олон үг уншсан багаар Лаборатори 4 дүгээр сургуулийн сурагч Х.Мишээл, Н.Билгүүн нар, шилдэг багаар сурагч О.Лхамсүрэн, Б.Хүслэн нар шалгарлаа.

“Жайка” ОУБ-ын хандив тусламжийн хүрээнд аймгийн хэмжээний 35 сургууль, 21 дотуур байр, 38 цэцэрлэгт нийт 93 автомакс, 440 ширхэг буюу 2200 литр ариутгалын бодис хуваарилсныг Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 1,9 сая төгрөгийг тээврийн зардалд гаргаж өгсний дагуу Улаанбаатар хотоос тээвэрлэн авчирч бүх сургууль цэцэрлэгүүдэд шуурхай зохион байгуулан хуваарийн дагуу тарааж өглөө.

“Дасгалаа хийж дархлаагаа дэмжье” сумдын ахмадуудын дунд зохион байгуулагдаж байгаа челленжийг сарын хугацаанд зохион байгуулж, 4 сумын нийт 18 ахмад оролцлоо.

## **2. Эрүүл мэндийн талаар:**

Эрүүл мэндийн даатгалын тасагтай хамтран өрхийн эрүүл мэндийн төвүүдэд “Магадлан итгэмжлэлийн бэлтгэл ажил хангах нь” сэдэвт цахим сургалтын зохион

байгуулж эрүүл мэндийн байгууллагын удирдлага, холбогдох эмч, мэргэжилтэнүүд нийт 36 хүнийг хамрууллаа.

Сумын төвөөс алслагдсан малчин өрхийн хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх “Халуун сэтгэл” явуулын амбулаторийн 16 эмч, мэргэжилтнүүдээс бүрдсэн явуулын 2, суурин 1 нийт 3 баг Түшиг суманд ажиллаж, 800 км зам туулж тусламж үйлчилгээг малчны хотонд үзүүллээ. Үзлэгт Эрүүл мэндийн газар, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Хушаат, Ерөө, Сант, Сайхан сумдын Эрүүл мэндийн төвүүдийн эмч, мэргэжилтэн нийт 76 өрхийн 258 иргэнд эмэгтэйчүүд, дотор, ЭХО, хүүхдийн чиглэлээр нарийн мэргэжлийн эмч нарын тусламж үйлчилгээ үзүүлж, нүүдлийн эмийн сангаар бөөний үнээр эмийн худалдаа ажиллуулсан.

### **3. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, нийгмийн даатгалын хүрээнд:**

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж хөнгөлөлтийн үйлчилгээг зорилтот бүлэгт түргэн шуурхай, хүнд сурталгүй чанартай хүргэх, халамжийн шинэ үйлчилгээг нэвтрүүлэхэд төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоотойгоор 17 сум 6 тосгонд мэргэшиж, дадлагажсан 35 мэргэжилтнүүдээр төрийн үйлчилгээг хүргэн ажиллаж байна.

Халамжийн санд улсын төсвөөс тайлант хугацаанд 32176 иргэнд 5337491.5 мянган төгрөгийг олгоод байна.

Үүнд:

- Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2350 иргэнд 1984401.9 мянган төгрөг
- Нийгмийн халамжийн тэтгэмжид 1626 иргэнд 431300.6 мянган төгрөг
- Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмжид 1493 иргэнд 241367.6 мянган төгрөг
- Жирэмсэн эхийн тэтгэмжид 1086 эхэд 86190.4 мянган төгрөг
- 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж 5240 эхэд 724577.0 мянган төгрөг
- Ихэр хүүхдийн тэтгэмжид 6 иргэнд 12000.0 мянган төгрөг
- Эхийн алдар одонгийн тэтгэмжид 8846 иргэнд 1140000.0 мянган төгрөг
- Насны хишиг тэтгэмжид 5018 иргэнд 394940.0 мянган төгрөг
- Өрх толгойлсоны тэтгэмж 245 иргэнд 93633.2 мянган төгрөг
- Ахмадын настанд олгох хөнгөлөлт, тусламжинд 649 ахмадын 22076.0 мянган төгрөг
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх хөнгөлөлт, тусламжинд 190 иргэний 22012.7 мянган төгрөг
- Хүнсний эрхийн бичгийн 5427 иргэнд 184991.9 мянган төгрөгийг тус тус зарцууллаа.

Халамжийн санд орон нутгийн төсвөөс тайлант хугацаанд орон гэрийн хөнгөлөлт, тусламжид 9 иргэнд 10800.0 мянган төгрөгийг зарцууллаа.

Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт 102 иргэний 82,179,125 мянган төгрөг төвлөрсөн.

### **4. Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар:**

“Зэвсэгт хүчний 100 жил”, “Залуучуудын байгууллага үүсч хөгжсөний 100 жил”-ийн ойг тохиолдуулан Залуучуудын хөгжлийн төв, “Залуучуудын эв нэгдэл” төрийн бус байгууллага, Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль, Хилийн 0243 дугаар ангитай хамтран 19 сурагчийг хамруулан “ЦЭРГИЙН НЭГ ӨДӨР” арга хэмжээг зохион байгуулж, цэргийн амьдралын хэв маяг, цэрэг хүний тэсвэр тэвчээр түүний бахархал, мөн чанарыг олон нийтэд сурталчиллаа.

Сумдын Залуучуудын элч нарт амьдрах ухааны 12 модуль хичээлийн 1,2,3 дугаар модуль хичээлийг цахимаар зохион байгуулж, сургалтад нийт 20 хүн оролцож сум орон нутагтаа амьдрах ухааны 12 модуль хичээллийг түгээн дэлгэрүүлэх чадвартай боллоо.

Алтанбулаг, Мандал сумын “Түр хамгаалах байр”-нд 3 хүүхэд, насанд хүрэгч 1 хүнд үйлчилгээ үзүүлж, ар гэрт нь эргэн нэгтгэж, хяналтад авч ажиллалаа.

“Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв”-өөс хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй холбоотой 17 дуудлага мэдээлэл бүртгэгдсэн.

Үүнд: Хүүхэд хамгааллын дуудлага 4, хяналтын дуудлага 4, хүүхдийн эрхийн 3, зөвлөгөө хүссэн дуудлага 3, мэдээлэл хүссэн дуудлага 2, зорилтот бус дуудлага 1 байна. Мөн сэтгэл санааны хүчирхийллийн 3, бэлгийн хүчирхийллийн 3, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 1, амиа хорлохыг завдсан 1, нийт 8 хүүхдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгсөн.

Мандал, Сайхан сумдын Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүдийг чадавхжуулах, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор “Хуулийг хэрэгжүүлэх нь” цахим сургалт зохион байгуулж, нийт 35 албан хаагч оролцож, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны аргачлал, үйл ажиллагаанд анхаарах асуудал болон хууль тогтоомжийн хэрэгжилтийг хэрхэн хангах арга зүйд суралцсан.

#### **Тав. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хүрээнд:**

##### **1. Мал эмнэлгийн үйлчилгээний талаар:**

“Мал эмнэлгийн төвийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх тухай” 01 тоот, “Мал эмнэлгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх тухай” 02 тоот, “Мал төхөөрөх, боловсруулах үйлдвэр цех, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн худалдан борлуулдаг цэгүүдэд хяналт шалгалт хийх тухай” 03 тоот, “Малын эмийн сан, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн дэргэдэх эмийн сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх тухай” 04 тоот удирдамжуудыг боловсруулан батлуулж сумдад хүргүүлж ажиллалаа.

Аймгийн хэмжээнд мал амьтны шилжилт хөдөлгөөн, харьяалалгүй малын судалгааг авахад 8 сумын нутаг дэвсгэрт Өвөрхангай, Төв, Баянхонгор, Улаанбаатар, Булган, Говь-Алтай, Орхон, Дундговь, Хэнтий, Дархан-Уул зэрэг 11 аймагаас 5113 адуу, 4098 үхэр, 36725 хонь, 21109 ямаа нийт 67645 толгой мал отор нүүдлээр шилжин ирж өвөлжлөө.

17 суманд 10469 өрхийн 1818519 толгой мал, амьтанд мал эмнэлгийн үйл ажиллагаа явуулж байгаа 46 МЭҮН-д 33 малын их эмч, 18 бага эмч нийт 51 малын эмч мэргэжилтэн, мал эмнэлгийн байртай 42 МЭҮН, яаралтай дуудлагын 53 тээврийн хэрэгсэлтэйгээр шуурхай бэлэн байдлыг ханган ажиллаж байна.

Амьд мал, түүний гаралтай түүхий эд бүтээгдэхүүн 279 гэрчилгээгээр адуу 511, үхэр 551, хонь 778, ямаа 782, тэмээ 7, гахай 19 нийт 2680 толгой мал шилжилт хөдөлгөөн хийсэн байна. Үүнээс /өөр аймаг сумаас ирсэн 1155, явсан 622, аймаг дотороо 903/ нийт 563 гэрчилгээгээр адуу 602, үхэр 781, хонь 1665, ямаа 1100, тэмээ 7, гахай 20, тахиа 50, нохой 2 нийт 4227 толгой мал, 7444 кг мах махан бүтээгдэхүүн, 990 кг сүү, сүүн бүтээгдэхүүн, түүхий эд 6 ширхэг нийт 8440 кг бүтээгдэхүүн мал амьтанд мал эмнэлгийн гэрчилгээг баталгаажуулан олгож мал эмнэлгийн нэгдсэн системд мэдээлэлийг тухай бүр оруулж мал эмнэлгийн гэрчилгээгээр баталгаажуулсан.

Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2021 оны А/04 тоот тушаалаар батлагдсан QR код бүхий мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээний цахим гэрчилгээ нэвтрүүлэх ажлын удирдамжийн дагуу мах, махан бүтээгдэхүүн худалдан

борлуулдаг Сүхбаатар сумын “Гурван мэргэд” зах, “Сэлэнгэ хөгжил, тохижилт үйлчилгээ” худалдааны төв, Мандал сумын “Сансар”, “Ану” зэрэг худалдааны төвүүдэд мах, махан бүтээгдэхүүний мал эмнэлгийн магадлан шинжилгээний QR код бүхий 51 гэрчилгээ олголоо.

Ариутгал халдваргүйтгэлийг 25 малын хашаа хороонд 8914 м2, 1 тээврийн хэрэгсэлд 10 м2, 3 зооринд 365 м2, 7 худаг уст цэгт 140 м2, бэлчээр 100 м2, устгалын цэгт 96 м2, сэг зэм 268, 912 м2 нийт 10537 м2 талбайд хийсэн.

Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх заавар журмын тухай 17 сумын Мал эмнэлгийн төвийн 22 эмчид заавар, зөвөлгөөг онлайнаар өгч, ХХААХҮЯ, МЭЕГ болон МЭГ-аас гаргасан тушаал, тогтоол шийдвэр болон цаг үеийн мэдээллийг Мал эмнэлгийн газрын фэйсбүүк хуудсанд 2 удаа тухай бүрт нийтэлсэн ба /Ковид-19/ цар тахлын хорио цээрийн үед гарсан тогтоол, захирамж, шийдвэрийг мөрдөн ажиллаж байна.

Халдваргүй өвчний тухайд нийт 557 толгой мал өвчилсөн ба үүнээс тэжээл боловсруулах эрхтний эмгэг 129 буюу 23.1 хувь, амьсгалын замын эрхтний эмгэг 96 буюу 17.2 хувь, Зүрх, судас мэдрэлийн системийн эмгэг 3 буюу 0.5 хувь, шээс бэлэг, үржлийн эрхтний эмгэг 163 буюу 29.2 хувь, бодис солилцооны эмгэг 54 буюу 9.6 хувь, эндемик өвчин 28 буюу 5 хувь, элдэв хордлого 50 буюу 8.9 хувь, гэмтэл, бэртэл 34 буюу 6.1 хувийг тус тус эзэлж байна. Халдваргүй өвчнөөр хорогдсон малын тоо 58 толгой буюу нийт өвчилсөн малын 10.4 хувийг эзэлж байгаа бол 499 толгой мал буюу 89.6 хувь нь МЭҮН-ийн авч хэрэгжүүлсэн эмчилгээний үр дүнд эдгэрсэн үзүүлэлттэй байна. Мөн Шөвөг яр, Нохойн гудрага зэрэг өвчнөөр өвчилсөн 58, үхсэн 2, эдгэрсэн 56, мал, амьтан тус тус өвчилж эдгэрсэн.

Баянгол, Түшиг, Мандал, Ерөө зэрэг сумдад ширх, трихинел, цахлай, хөх ширх зэрэг өвчнүүд зонхилон гарч нийт 974 толгой мал, амьтан өвчилснөөс 944 толгой мал, амьтан буюу 100 хувийн эдгэрэлттэй байна.

Сүхбаатар сумын хэмжээнд хүнсний зах дэлгүүрт худалдан борлуулж байгаа мах махан бүтээгдэхүүний 3640 кг үхрийн махны 30 дээж, 987 кг хонины махны 47 дээж, 220 кг ямааны 11 дээж, 540 кг адууны махны 6 дээж, сүү сүүн бүтээгдэхүүний 340 л сүүний 3 дээж, 90 л тарагны 3 дээж, 40 кг ааруулын 2 дээж, 40 кг цөцгийний 2 дээжинд ариун цэврийн магадлан шинжилгээг стандарт арга зүйн дагуу хийж гүйцэтгэсэн.

## **2. Хөдөө аж ахуйн талаар:**

Улсын Онцгой комиссын даргын 2020 оны “Хүнсний хангамжийн удирдлагын шуурхай штаб байгуулах тухай” 21 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын 2020 оны “Хүнсний хангамж, нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулах тухай” А/309 тоот захирамжийн хэрэгжилтийг хангуулан, аймаг орон нутгийн иргэдийг хүнсний бүтээгдэхүүнээр хангах, нөөц бүрдүүлэлт, дэлгүүрүүдийн борлуулалтын мэдээг өдөр тутам авч ХХААХҮЯ-нд мэдээлэл өгч байна.

Сэлэнгэ Хүнс, хөдөө аж ахуйн газрын фэйсбүүк хуудас орон нутгийн хэвлэл мэдээллийн сувгууд болон аймгийн Засаг даргын газар болон ХХААХҮЯ-ны цаг үеийн мэдээ, мэдээллүүдийг тухай бүрт байршуулан иргэдийг мэдээллээр хангах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

2021 оны хаврын тариалалтын бэлтгэлийг хангахад чиглэсэн олон ажил арга хэмжээг төлөвлөн улаанбуудай, төмс, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч Засгийн газраас хөнгөлөлттэй зээл, төмс, хүнсний ногооны үр, техник тоног төхөөрөмж, ургамал хамгааллын бодис, шатахууныг хөнгөлөлттэй нөхцөлөөр олгохоор ажиллаж, сумдын Засаг дарга нар нийт тариалах талбайн 80 доошгүй хувьд

улаанбуудай тариалах гэрээ хийх, орон нутагтаа “Өрхийн тариалан” хөдөлгөөн өрнүүлэх замаар 2021 оны тариалалтын төлөвлөгөөг давуулан тариалах чиглэл хүргүүлэн ажиллаж байна.

Мөн улаанбуудай болон хүнсний ногооны үрийн хэрэгцээг шинэчлэн тооцож, дутагдах үрийн хүсэлтэй зохиалгаа яаралтай гаргаж ирүүлэх, аж ахуйн нэгжүүдийн тариаланчид, ногоочид, мэргэжилтэн, удирдах ажилтнуудыг нэгдсэн журмаар PCR шинжилгээнд хамруулж, хөдөө аж ахуйн нэгж, байгууллагуудтай үр, шатахуун, техник, тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодис, сэлбэгийн гэрээ байгуулах боломжийг бүрдүүлэхэд онцгой анхаарал хандуулан иргэн аж ахуйн нэгжүүдээс үрийн захиалга болон Улаанбаатар хот, өөр бусад аймаг орон нутгаас ирэх иргэдийн судалгааг гаргаж байна.

Аймгийн хэмжээнд хаврын тариалалттай холбогдуулан Улаанбаатар хотоос нийт эхний ээлжинд вакцинд хамрагдах 273 иргэний мэдээлийг авч Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, аймгийн Онцгой комисст нэрсийг гарган хүргүүлсэн.

Газар тариалангийн үйлдвэрлэлийн техникийн шинэчлэл хийх зорилгоор ОХУ-ын Засгийн газрын хөнгөлөлтэй зээлийн эх үүсвэрээр ОХУ-д үйлдвэрлэгдсэн үр тариа, тэжээл, тариалалтад зориулсан трактор, комбайн, хөдөө аж ахуйн техник тоног төхөөрөмжийн захиалга авч Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлсэн.

Том малын хорогдлын мэдээг 7 хоног бүр авч холбогдох газарт хүргүүлэн ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 2458 толгой том мал хорогдсон ба үүнээс хээлтүүлэгч 17 толгой мал хорогдсон.

Аймгийн хэмжээнд 707333 эх мал төллөхөөс 03 дугаар сарын байдлаар 61425 эх мал төллөсөн нь нийт төллөх малын 8,6 хувь нь төллөж төл бойжилт 99,0 хувьтай байна.

### **3. Байгаль орчны талаар:**

“Олон Улсын ойн өдөр”-т зориулан зохион байгуулсан “Монгол орны ойн нөхөн сэргээлтийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага” сэдэвт үндэсний V хуралд /цахим/ “Орон нутгаас ойн нөхөн сэргээлтийн талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ” сэдвээр Ойн албаны дарга Г.Цэнгэлзаяа илтгэл тавьж оролцсон. Мөн хуралд Ойн албаны мэргэжилтнүүд, сумын болон сум дунын Ойн ангийн инженер техникчид, Хүдэр, Мандал, Ерөө зэрэг сумдын ойн мэргэжлийн байгууллагын төлөөлөл оролцсон.

Ойн хөнөөлт шавжтай тэмцэх тэмцлийн ажил гүйцэтгүүлэх ажлын даалгавар бэлтгэн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж, тендер зарлагдан, тендерийн үнэлгээний хороо байгуулагдан, гүйцэтгэгчийг сонгон шалгарууллаа. Бэлчирийн бүсийн сум дундын Ойн ангид дэмжлэг үзүүлэх ажлын гэрээг байгуулаад байна.

Ойн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлыг Хүдэр, Баруунбүрэн сумдад хийж, Хүдэр суманд 22, Баруунбүрэн суманд 3 ойн мэргэжлийн байгууллага хамрагдсан.

Ойгоос мод бэлтгэхээр 157 талбайд 2193 га талбайг тусгаарлаж 301.571 м3 хэрэглээ, 5.764 м3 түлээ бэлтгэж орон нутгийн төсөвт 54.8 сая төгрөг төвлөрсөн байна.

Биотехникийн арга хэмжээг сумын болон сум дундын 5 Ойн ангиудаар дамжуулан ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөлүүдээр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан ажиллаж байгаа ба санхүүжилт 1,2 сая төгрөгийг шилжүүлээд байна.

### **4. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын талаар:**

Засгийн Газрын 2019 оны 239 дүгээр тогтоолын дагуу “Дархан-Сэлэнгийн автозамаас Шаамар-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг-Зэлтэрийн боомт чиглэлийн 120,85 км хатуу хучилттай автозам төсөл”-ийн барих шилжүүлэх концессын гэрээгээр гүйцэтгэх



ажлын хүрээнд замын автозамын трасс дагуух газрыг замын ажил дуустал түр хугацаагаар ашиглуулах газрын асуудлыг холбогдох хууль тогтоомж, журамд заасны дагуу олгохыг 4 сумын Засаг даргад аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар 22-ны 01/70 тоот албан бичгээр чиглэл хүргүүлж, дээрх чиглэлийн дагуу 4 сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тодотгол хийлгүүлэх, сумдын ИТХ-аар хэлэлцүүлэх газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд оруулах ажлыг зохион байгууллаа.

Монгол Улс, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улсад “Хүнсний ногооны үйлдвэрлэлд нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх” төслийн санхүүжилтээр Сэлэнгэ аймгийн Сүхбаатар суманд төмс хүнсний ногооны 1000 тн багтаамжтай агуулахыг байгуулах боломжит газрын асуудлыг шийдвэрлүүлэхээр аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газраас ирүүлсэн хүсэлтийг судлан Сүхбаатар сумын 8-р баг Мал эмнэлгийн хойд талд байршил бүхий 1 га газрыг зорьны зориулалтаар эзэмшүүлэх боломжтой гэж үзэж Сүхбаатар сумын иргэдийн Төлөөлөгчдийн 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн батлуулав.

Улаанбаатар хотоос Дархан-Уул аймгийн чиглэлийн 202.42 км авто замын зурвас газарт орсон барилга байгууламж, сурталчилгааны самбар зэргийг нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулж авто замын барилгын ажил эхлэхэд саадгүй болгосон талаарх тайланг зам тээврийн яаманд хүргүүлж ажиллалаа.

Аймгуудын Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга нарын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд заасан “Аймгийн төвөөс бусад сумын барилга байгууламжийн мэдээллийг хот байгуулалтын кадастрын цахим системд бүртгэх” ажлын хүрээнд аймгийн ГХБХБГ-ын даргын 2021 оны А/13 тоот тушаалаар 9 сум, 2 тосгонд ажиллаж, мэдээллийн санд бүртгэх 583 барилга байгууламжийг доорх хүснэгтэд зориулалт бүрээр харууллаа.

Сэлэнгэ аймгийн барилга байгууламжийн судалгаа /зориулалт бүрээр/												
Д/д	Сумын нэр	Орон сууц	Соёлын барилга	Төрийн байгууллага	Боловсролын байгууллагын барилга	Эмнэлгийн барилга байгууламж	Худалдаа нийтийн хоол ахуй үйлчилгээний барилга	Үйлдвэрийн барилга байгууламж	Мэдээлэл холбоо сүлжээний барилга байгууламж	Инженерийн дэд бүтэцийн барилга	Бусад барилга байгууламж	Нийт
1	Баруунбүрэн		1	4	4	1	19	1	1	1	9	41
2	Ерөө	4	4	18	6	1	45	15	1	2	26	122
3	Зүүнбүрэн		1	7	4	1	9		1	2	10	35
4	Орхон		2	3	4	2	4		1	1	13	30
5	Орхонтуул		1	4	5	2	5		1	2	8	28
6	Сант		1	1	8	4	4	1	1	2	22	44
7	Хушаат		1	4	2	2	9		1	2	48	69
8	Хүдэр		2	1	3	2	39	25	1	2	43	118
9	Шаамар	16	1	2	6	1	21	1	1	1	46	96
	<b>Нийт</b>	<b>20</b>	<b>14</b>	<b>44</b>	<b>42</b>	<b>16</b>	<b>155</b>	<b>43</b>	<b>9</b>	<b>15</b>	<b>225</b>	<b>583</b>

Зураг төсөл хянасан байдал:

- Жавхлант сумын “Хүүхдийн тоглоомын талбайд хашаа барих, бетонон шал цутгах ажил”-ын
- Жавхлант сумын “Хүүхдийн тоглоомын талбай тохижуулах ажил”
- Жавхлант сумын “Жавхлант сумын хаяг, самбарын ажил”-ын зураг төсвийг
- Жавхлант сумын Бумбат 1-р багт малын худаг шинээр барих ажил

- Жавхлант сумын “Моностой 2-р багт малын худаг шинээр барих ажил”-ын
- Орхон сумын “Гадна инженерийн шугам сүлжээний ажил”-ын зураг төсвийг
- Хүдэр суманд баригдаж буй 10 ортой эмнэлгийн барилгын зураг төсөл
- Ерөө сумын 2- багт “Хүүхдийн тоглоомын талбай барих ажил”-ын зураг төслийг
- Сайхан сумын Номгон тосгоны “Ерөнхий боловсролын сургуулийн гадна хашааны ажил”-ын зураг төслийг
- Сайхан сумын Номгон тосгоны “Явган замын ажил”-ын зураг төслийг
- Хушаат сумын Мөнхтолгой 2-р багт баригдах “Зоорийн барилгын ажил”-ын зураг
- Орхонтуул сумын “Нутгийн удирдлагын ордны өмнөх талбайг засаж цутгах ажил”
- Орхонтуул сумын “Жишиг гудамж байгуулах, зам тавих ажил”
- Орхон сумын “Гадна инженерийн шугам сүлжээний ажил”-ыг тус тус хянаж, холбогдох норм дүрмийг хангаж гүйцэтгэх тайлбарыг холбогдох хэлтэст хариуг хүргүүлсэн.
- Мандал сумын ерөнхий боловсролын 1-р сургуулийн вакуум цонх, чулуун шал, халаалтын засвар.
- Сүхбаатар сум Биеийн тамир спортын газрын хана, шал солих засварлах ажил.
- Сүхбаатар сум Биеийн тамир спортын газрын фасадны зураг төсөл.
- Шаамар сум Дэлгэрхаан 1-р багийн нутагт шинээр суурьшиж буй айл өрхийн гадна цахилгаан хангамжийн ажлын зураг төсвийг хяналаа.

Архитектур төлөвлөлтийн даалгаврыг “Зүүн Мандал агро ХХК”-ий Усны үйлдвэрийн барилга, Сайхан сум “Залуучуудын хөгжлийн ордон”-д гаргаж өгсөн.

Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг Сүхбаатар, Мандал, Сайхан сумдад байршилтай гэр хорооллын гудамж, зам талбайн гэрэлтүүлгийн ажилд, Жавхлант сумын Соёлын төвийн барилгын их засварын ажлуудад тус тус олгов.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын 2021 А/14 тоот тушаалын дагуу байгууллагын үйл ажиллагааны үр дүн, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор “Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд барилга, байгууламжийн мэдээллийг бүртгэх ажил”-ын хүрээнд Хүдэр, Ерөө, Хушаат, Баруунбүрэн, Сант, Орхонтуул, Орхон сумдад ажиллав.

#### **5. Орон нутгийн өмчийн талаар:**

2021 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим худалдан авах ажиллагааны систем /www.tender.gov.mn/-д 1 агентлаг, 17 сум, 15 сургууль цэцэрлэгийн төлөвлөгөөг хянан баталгаажуулж Сангийн яаманд илгээж батлуулан ажиллалаа.

Цахилгааны эх үүсвэрийн шугам татах /Шаамар сум/, Дугуйт ачигч ковш худалдан авах /Шаамар сум/, Сумын эмнэлэгт эхо аппарат авах /Ерөө сум/, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ажлын хэрэгцээнд автомашин авах, аймгийн ИТХ-ын төлөөлөгч нарт таблет худалдан авах, эм эмнэлгийн хэрэгсэл 2021-01-06, 2021-01-29 тус тус зарлан үр дүн гарсан байна. Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Түшиг сум/ 2021-03-29 нээсэн үнэлгээ хийж байна. Баруунбүрэн, Ерөө, Шаамар, Түшиг, Цагааннуур сумдад ойн хөнөөлт шавжийн тэмцлийн ажлыг ойн мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх, Баруунбүрэн, Ерөө, Шаамар, Түшиг, Цагааннуур сумдад ойн хөнөөлт шавжийн тэмцлийн ажлыг ойн мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх 2021-03-30 нээнэ. Ойн хөнөөлт шавж, түймэрт нэрвэгдэж доройтсон ойд ойжуулалтын ажлыг 200 га талбайд мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх 2021-04-01 нээнэ. Биологийн

лаборатори /Сэлэнгэ, Мандал, Сант, Сайхан, Сүхбаатар сум/ Дулааны шугам шүлжээ тавих /Орхон сум/ тус тус 2021-04-29 нээхээр цахим системд нийтлэн ажиллаж байна.

### **Зургаа. Сум орон нутгийн ажил үйлчилгээний талаар:**

#### **Алтанбулаг сум:**

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ сард танхимаар 1 удаа хуралдаж

1. Хөрөнгө актлах тухай
2. Шагнал тодорхойлох тухай
3. Багийн нэршлүүдийг баталгаажуулхаар уламжлах тухай
4. Бодлогын хороодын төлөвлөгөө батлах тухай
5. Ухуулах хуудас, самбар байршуулах байршил тогтоох тухай зэрэг асуудлыг хэлэлцэж баталсан.

Аймгийн Засаг даргын 2020 оны “Өндөржүүлсэн бэлэн байдлын хугацааг сунгах тухай” А/348 тоот захирамж, сумын Засаг даргын 2021 оны “Эргүүл жижүүрийн хуваарийг сунгах тухай” А/36 тоот захирамжийн дагуу автозамын хяналтын 1 цэг, шуурхай штаб зэрэг эргүүл жижүүрт төр төсвийн байгууллагын 64 албан хаагчид үүрэг гүйцэтгэж байна.

Алтанбулаг сумын Засаг даргын Тамгын газрын даргын баталсан “Хаваржилтын нөхцөл байдалтай танилцах, малчдад мэдээлэл зөвлөмж өгөх” удирдамжийн дагуу Засаг даргын Тамгын газрын 5, Эрүүл мэндийн төвийн 2 ажилтан албан хаагчид Цөх 3-р багийн малчин 40 өрхийн 76 иргэнд аймаг сумаас гарсан бодлого шийдвэр, “Гэр бүлийн тухай хууль”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”-ийн иргэний эрх, үүрэг, нийгмийн даатгалын хөнгөлөлттэй үнээр эм бэлдмэл авах талаарх мэдээллийг хүргэж ажиллалаа. Эрүүл мэндийн үзлэг үйлчилгээг 7 өрхийн 8 том хүн 3 хүүхдэд үзүүлсэн.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан “Сэтгэл хөдлөлөө удирдах нь”, “Албан хаагчдын идэвх оролцоог нэмэгдүүлэх” цахим сургалтад давхардсан тоогоор төр, төсвийн байгууллагын 42 ажилтан албан хаагч хамрагдсан. Монгол Улсын боловсрол шинжлэх ухааны сайдын 2021 оны “Түр журам батлах тухай” А/58 тоот тушаалын дагуу 03 дугаар сарын 01-ний өдрөөс сургууль цэцэрлэгийн үйл ажиллагаа эхлэх болсонтой холбогдуулан сумын Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг сургууль цэцэрлэгийн хичээлийн бэлтгэл бэлэн байдал, тулгамдаж буй асуудлын талаар санал хүсэлттэй танилцан мэргэжил арга зүйн зөвлөгөө хүргэн ажилласан.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны “Хугацаа тогтоох тухай” 14 дүгээр тогтоолын дагуу сум хөгжүүлэх сангийн төслийг 02 дугаар сарын 26-ны өдрөөс 03 дугаар сарын 19-ний хооронд зарлан нийт 24 төсөл хүлээн авч, сонгон шалгаруулах ажлын хэсэг хуралдаж, ирсэн 24 төслөөс 7 төсөлд нийт 80.0 сая төгрөгийн зээл олгохоор шийдвэрлэсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд халдварт бус өвчлөл болох артерийн гипертензи, чихрийн шижингийн хэв шинж, умайн хүзүү, хөх элэгний хавдрын эрт илрүүлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт 1443 иргэдийг хамруулахаас 100 иргэнийг хамруулсан. Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611 тоот тушаалын дагуу “Эх хүүхэд эрүүл мэнд” уриан дор сумын шинээр төрсөн 14 нярайд эх баригч эмч эргэлт үзлэг хийсэн. Мөн 1,2,3 дугаар цэцэрлэгийн танхимаар хичээллэж байгаа нийт 242 хүүхдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 100 хувь хамруулсан.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/15, сумын Засаг даргын 2021 оны А/14 тоот “Бүх нийтийн ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг эрчимжүүлэх тухай” захирамжийн дагуу 7 хоног бүрийн 5 дахь өдөр бүр 16 албан байгууллагын 16371 м<sup>2</sup>, худалдаа

үйлчилгээний 19 дэлгүүрийн 2475 м2, 64 айлын орц подволь, замын пост, 3284 м2 талбайд 3 удаагийн давтамжтай ариутгал халдваргүйжүүлэлт хийгдсэн.

Улаанбаатар хотоос ирж гэрийн ажиглалтад орсон 97 иргэнээс ПСР, 13 иргэнээс түргэвчилсэн оношлуурыг тус тус авч бүгд сөрөг гарсан.

Засгийн газрын 2021 оны 47 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 18-р тушаал, Боловсрол соёл шинжлэх ухааны сайдын 2021 оны “Түр журам батлах тухай” А/58 тоот тушаал, Боловсрол, соёл, урлагийн газрын даргын 54 тоот албан бичгийн дагуу сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах арга хэмжээг авч гамшгийн үеийн бэлэн байдлыг ханган ажиллаж сургалтын үйл ажиллагааг танхимаар эхлүүллээ. СӨБ-д танхимаар 201 хүүхэд зайнаас 29 хүүхэд хамрагдаж байна. Ерөнхий боловсролын сургуулийн 799 сурагчаас цахимаар 16 сурагч суралцаж танхимын сургалтын хамрагдалт 89-92 хувьтай байна.

Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газраас зохион байгуулсан “Танхимын хичээл сургалтыг эхлүүлэх бэлтгэл ажил, асуудал шийдэл” сургалтад сургууль, цэцэрлэгийн 9, “Хүний нөөцийн системийн баяжилт” сургалтад 6 ажилтан албан хаагч хамрагдсан. Дэлхийн усны өдөр буюу 03 дугаар сарын 22-нд ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 16 бүлгийн 348 сурагчдад “Усны үнэлэмж-үнэ цэнэ” сэдэвт шторк үзүүлж “Хог хаягдал биднийг мэдлэг бүтээгч болгодог” сэдэвтэй сурагчдын бүтээлээр үзэсгэлэн гаргасан.

#### **Баруунбүрэн сум:**

“Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж суманд Улаанбаатар хот болон бусад аймаг сумаас ирсэн иргэдийг 14 хоногийн гэрийн тусгаарлалтад оруулан, тусгаарлалтад орсон айл өрхүүдийн хашааны гадна таних тэмдэг бүхий санамжийг тухайн өдрийн жижүүрүүд байрлуулан ажиллаж байна.

Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 22 дугаар тушаал, сумын Засаг даргын 2021 оны “Шуурхай штабыг шинэчлэн байгуулах тухай” А/26 тоот захирамжийн дагуу сумын Онцгой комиссын Шуурхай штабын бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт орж Шуурхай штаб нь 5 багт хуваагдан ажиллаж байна. Үүнд:

- Ажиллагаа зохицуулалт, тусгаарлан ажиглаж үйл ажиллагааг зохицуулах баг
- Хяналт шинжилгээ, үнэлгээ, төлөвлөлтийн баг
- Нөөц хангалтын баг
- Мэдээлэл технологи, харилцаа холбооны баг
- Захиргаа, санхүүгийн баг

Сумын Засаг даргын 2021 оны “Түр журам батлах тухай” А/37 тоот захирамжийн дагуу тус суманд оршуулгын буюу буяны үйл ажиллагаа зохион байгуулах түр журмыг боловсруулан 2021 оны 03-р сарын 23-ны өдөр Улаанбаатар хотоос суманд 2 газарт буяны ажил ирж тухайн айлуудыг тусгаарлалтад авч түр журмын дагуу 2 хэсэг хяналтын түр цэг ажиллаж байна.

“Эрүүл мэндийн цахим гүйлт-2021” биеийн тамирын арга хэмжээнд сумын иргэд, албан байгууллагуудыг уриалан “Баруунбүрэн сумын гүйгчид-2021” группыг нээн шинэ мэдээ мэдээлэл, заавар зөвөлгөөг өгөн ажиллаж байна.

“Коронавируст халдвар /COVID-19/-ын эсрэг ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд цагийг зөв боловсон өнгөрүүлэх, дархлааг дэмжих, хөдөлгөөний дутагдалаас урьдчилан сэргийлэх зорилгоор бага, дунд, ахлах ангийн сурагчдын дунд **“Дасгалаар дархлаагаа дэмжье”** цахим дасгалын уралдааныг 02 дугаар сарын 25-аас

03 дугаар сарын 15-ны хооронд зарлан зохион байгуулан ажиллалаа. Цахим уралдааныг Орхон аймаг дахь “Тунгалаг Тамир Туяарах” ХХК-ий захирал “MON set Nine sport” брэндийн үүсгэн байгуулагч Э.Тунгалаг ахлах, дунд, бага ангийн төрөлд 1 дүгээр байр эзэлсэн сурагчдад биеийн тамирын өмд цамц хосоор нь 100 хувь үнэгүй оёулах эрхийн бичгээр, “Бүрэнтоогоот” ХХК захирал “Бүрэн” мини маркет дэлгүүрийн эзэн Э.Баярмагнай ангилал тус бүрийн 2 дугаар байранд орсон сурагчдад бэлтгэлийн хувцас 100 хувь үнэгүй оёулах эрхийн бичгээр, “Таван шар баялаг хоршоо”-ны захирал Л.Лувсан ангилал тус бүрийн 3 дугаар байранд орсон сурагчдыг мөнгөн шагналаар тус тус ивээн тэтгэн нийгмийн хариуцлагын хүрээнд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллалаа.

Аймгийн Биеийн тамир, спортын газраас эхлүүлсэн “Дасгалаа хийж дархлаагаа дэмжье” ахмадын дунд зохиогдож буй challenged сумынхаа ахмадуудыг бэлдэн оролцууллаа.

03 дугаар сарын 02-07-ны өдрүүдэд сумын Засаг даргын Тамгын газар, Соёлын төв хамтран “Ээждээ захидал бичээрэй” уралдааныг хүүхэд багачууд болон сумын иргэдийн дунд зохион байгуулж насанд хүрэгсэдийн 3 байр, хүүхэд 3 байраар шалгаруулаад байна.

*Коронавирусийн халдварын болзошгүй эрдслээс урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд:*

Сумын Засаг даргын 2021 оны “Халдвар хамгааллын дэглэм, ажлын хариуцлагыг өндөржүүлэх тухай” А/02 тоот захирамжийн хүрээнд Бургалтайн 2-р багийн нутаг “Хөшөөн дэв”-д ажиллаж буй 24 цагийн хяналтын цэгт ажиллах жижүүрийн хуваарь, хариуцлагатай эргүүл, жижүүрүүдийн ажиллах журмыг баталж нийт төрийн албан хаагчдад үүрэгжүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хяналтын цэгээс өдөр бүрийн 11:30, 17:30, 20:30 минутад дамжин өнгөрсөн болон сум руу орсон, сумаас гарсан машин, зорчигчийн судалгааг авч холбогдох газруудад мэдээллэн ажиллаж байна. Тус хяналтын постонд цагдаагийн 2 албан хаагч, Сайхан сумын Онцгой байдлын газрын 1 албан хаагч, ЗДТГ-ын 1 албан хаагч, ЭМТ-ийн 1 эмч нийт 5 албан хаагч өдөр бүр хуваарийн дагуу жижүүрлэн ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны “Бүх нийтийн ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг эрчимжүүлэх тухай” А/15 тоот захирамж, сумын Засаг даргын 2021 оны “Ажлын цагт зохицуулалт хийж, ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг эрчимжүүлэх тухай” А/14 тоот захирамжийн дагуу сумын хэмжээнд долоо хоног бүрийн Баасан гарагт ариутгал, их цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж нийт 44 байгууллагын 60400 м2 талбайд ариутгал хийж, 43 байгууллага, объект их цэвэрлэгээний ажлыг зохион байгуулсан.

Баруунбүрэн, Сайхан, Сант, Орхон, Орхонтуул сумдын Онцгой комисс Сайхан сумын Номгон тосгоны хяналтын цэгийн, шалган нэвтрүүлэх үйл ажиллагааг сайжруулж, үүрэг гүйцэтгэж буй албан хаагчдын ажиллах нөхцөл, хүнс хоол, бусад хангамжийг 5 хоногоор хариуцан ажиллахаар болсон.

Тус сумын Бургалтай 2-р багийн нутаг “Хөшөөн дэв”-д байрлаж буй хяналтын цэгт халдварын голомт, эрсдэл бүхий бус нутгаас ирж буй иргэдээс коронавируст халдвар /Ковид-19/-ын шинжилгээ авах явуулын түр байрыг бэлтгэн ажиллалаа.

Аймгийн Онцгой комиссын “Хөдөлгөөний хязгаарлалтын хугацааг сунгах тухай” 06 дугаар тогтоолоор 03-р сарын 14-ний өдрийн 06:00 цагаас 03-р сарын 31-ний өдрийн 06:00 цаг хүртэл иргэдийн зорчих хөдөлгөөнийг хязгаарласан тухай сумын цахим хуудас, фэйсбүүк хуудсаар сурталчлан ажиллаж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад “/Ковид-19/ вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, Хүүхдийн ахуйн осол гэмтэл”-ээс урьдчилан сэргийлэх сургалтыг сумын Эрүүл мэндийн төвөөс 210 хүүхдэд сургалт хийсэн.

2021 он гарсаар 03 дугаар сарын байдлаар цахим бүргэлийн системд хүнсэнд адуу 54 толгой, үхэр 89 толгой, хонь 833 толгой, ямаа 804 толгой, мах 68207 кг бичигдсэн байна.

Өөр аймаг, сумаас ирэх амьд мал, амьтны шилжилт хөдөлгөөнд байнга хяналт тавин бусад аймаг сумын удирдлага, албан хаагчидтай утсаар холбоо барьж, хамтран ажиллаж байна. Баянхонгор аймгийн Бууцагаан 2 дугаар багаас отор нүүдлээр ирсэн иргэний малын зүй бусаар хорогдол тором 2, төлөг 8, борлон 6, нийт 16 толгой төл мал байсныг сумын төвийн устгалын цэгт сэг зэмийг устган 60 м2 талбайд ариутгал, халдваргүйжүүлэлт хийсэн.

“Мал эмнэлгийн мэргэжлийг зохицуулах комисс гэж юу вэ? МЭ-ийн боловсролын тогтолцооны хэлэлцүүлгийн дүгнэлт” сэдэвт цахим сургалтад Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч хамрагдлаа.

Сумын Орхон бүсийн сум дундын ойн ангиас мод модон материалын гарал үүслийн гэрчилгээ 58 ширхэг бичигдэж өөр аймаг сумруу тээвэрлэсэн байна.

Дээд газруудаас ирсэн хяналт шалгалт хийх удирдамжийн дагуу Баруунбүрэн суман дахь Сум дундын Ойн ангийн үйл ажиллагаанд “Төрийн хяналт шалгалтын тухай”, “Ойн тухай тухай”, “Байгаль орчныг хамгаалах тухай” хууль тогтоомжууд, тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад дүрэм журам, тушаал холбогдох норм, стандартын хэрэгжилтийн байдалд Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын холбогдох мэргэжилтнүүд хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн.

#### **Баянгол сум:**

Аймгийн Онцгой комиссын 2021 оны А/07 тоот захирамжийг сум орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэн улс, аймгийн Онцгой комиссоос ирүүлсэн заавар зөвлөмжийг удирдлага болгон ажиллаж байна.

Сумын хэмжээнд Цагдаагийн хэсэг, Гал түймэр унтраах 40-р анги, Улсын нөөц, хүмүүнлэг тусламжийн анги, Засаг даргын Тамгын газар хамтран 24 цагийн пост 2 цэгт 4 албан хаагч үүрэг гүйцэтгэж нэмэлтээр хойд чиглэлээс ирж буй тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих зорилгоор нэг пост нэмж гарган ажиллаж байна.

Сумын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан сумын Онцгой комиссын шийдвэрийн дагуу 03 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн зарим байгууллага, үйлчилгээний газруудын үйл ажиллагааг хааж, хүнсний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч аж ахуй нэгж, байгууллагууд өглөөний 09:00-20:00 цагийн хооронд ажиллаж, мөн хугацаанд шар айраг, оргилуун дарсыг худалдан борлуулахын түр хугацаагаар хязгаарласан.

Сумын Засаг даргын 2020 оны “Шуурхай штаб байгуулж, ажлын тусгай горимд шилжүүлэх тухай” А/254 дүгээр захирамжийн дагуу Засаг даргын Тамгын газрын байранд шуурхай штабыг урд цагдаагийн постод нэмэлтээр байрлуулан 24 цагийн хариуцлагатай жижүүрийг томилж, үүссэн нөхцөл байдалтай холбоотой мэдээ, мэдээллийг аймгийн Онцгой комисс болон холбогдох байгууллагад 94244802 дугаарын утсаар болон цахимаар буюу [Bayangol.ontsgoi.komiss@gmail.com](mailto:Bayangol.ontsgoi.komiss@gmail.com) хаягаар хүргүүлэн ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/15 захирамжийн дагуу сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төр төсвийн байгууллагууд нийт 3700 м2 талбайд ариутгал халдваргүйтгэлийг хийж гүйцэтгэлээ.

Засгийн газрын 2020 оны “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 194 дүгээр тогтоолын хавсралтад заагдсан хязгаарлалт тогтоохгүй төрийн байгууллага, хуулийн этгээдүүдийн үйл ажиллагааны жагсаалтад багтсан шалтгаанаар 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн нийт 115 иргэний хүсэлтийг шийдвэрлэсэн.

Олон Улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг угтан “Ижийдээ захидал бичээрэй” уралдааныг зохион байгуулж, 18 хүн оролцож шилдэг 5 захидлыг шалгаруулан шагнаж урамшуулсан. Мөн “Ээжтэйгээ хамт” гэрэл зургийн цахим уралдааныг зохион байгуулж 120 гаруй хүн оролцон шилдэг 5 зургийг шалгаруулан шагнаж урамшууллаа. 03 дугаар сард Соёлын төв нь 5 удаагийн соёлын арга хэмжээ 175 хүнийг хамруулан ажиллалаа.

Ерөнхий боловсролын сургуулийн 6-9 дүгээр ангийн 216 охид, 198 хөвгүүдэд “ХҮЧИНДЭХ” гэмт хэргээс өөрсдийгөө хамгаалах мөн гэмт хэрэг, зөрчлөөс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж бэлтгэн хүргэж ажиллалаа.

Сумын Эрүүл мэндийн төв Коронавируст халдварыг илрүүлэх түргэвчилсэн шинжилгээг 56 иргэнд, ПГУ шинжилгээг 67 иргэнд тус тус хийсэн.

Эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч тусгай мэргэжилтнүүд 03 дугаар сарын 12-ны өдрөөс шалган нэвтрүүлэх постын бүртгэл дээр жижүүр хийж нийт 2897 хүнийг бүртгэж нэвтрүүлсэн.

Гэрийн тусгаарлалтад 77 иргэнийг хянаж, 38 иргэн гэрийн тусгаарлалтаас гаргасан.

Эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлж буй иргэдэд “Халдвараас сэргийлье” сэдэвт гарын авлага бэлдэж 217 ширхэгийг тараасан. Эрүүл мэндийн газраас зохион байгуулсан “Ковид-19” халдвараас сэргийлэх арга хэмжээ сэдэвт цахим сургалтад 22 ажилтан хамрагдсан.

Баянгол сумын постоор нэвтэрч буй 182 авто машин, байгууллагын 28942 м2 талбай, Ерөнхий боловсролын сургуулийн 126 м2 тус тус ариутгал хийсэн.

Сумын хэмжээнд 19 аж ахуй нэгж, 4 иргэн 8785 га-д үр тариал, тэжээл, тосны ургамал тариалахаар төлөвлөгөө ирүүлээд байна. Төрөл бүрээр задалбал буудай 7012 га-д, тэжээлийн ургамал 543 га-д, төмс 100 га-д хүнсний ногоо 80-85 га-д тариална.

Шар усны үер, голын мөс цөмрөх аюулаас сэргийлэх зорилгоор Хараа голын дагуу үер усны эргүүл шалгалтыг 2 удаа хийж, Хараа багийн “Найрамдлын хэсэг”, Гонир багийн “Дэрст”-ийн 20 айлд шар усны үерээс сэргийлэх, голын мөс цөмрөх аюултай сэрэмжлүүлэг тарааж ажилласан.

Бичил уурхай эрхлэгч 1 нөхөрлөлд Экологи-эдийн засгийн үнэлгээний хохирлыг тогтоож, акт үйлдэж, Мандал сумын Цагдаагийн хэлтэст хүргүүлж ажилласан.

/COVID-19/ цар тахлын үеийн дэглэмийг сахиулах, гамшгийн үеийн бэлэн байдлыг хангуулах зорилгоор аймгийн Мэргэжлийн хяналтын газраас өгсөн зөвлөмжийн дагуу ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, 1-р цэцэрлэг, “Бүжинхэн” цэцэрлэгт байнгын шалгалтыг 9 удаа, хүнсний худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудаар 1 удаа хийж, зөрчлийг илрүүлж, зөрчлийг арилгах заавар зөвлөмж өгч ажиллалаа.

#### **Ерөө сум:**

Сумын Онцгой комисс цаг үеийн байдал болон аймаг улсын Онцгой комиссын гаргаж буй шийдвэрийг үндэслэн 4 удаа хуралдаж холбогдох шийдвэрүүдийг гарган, 2267 иргэн яаралтай бичиг гаргуулж, асуудлаа шийдвэрлүүлсэн байна.

Мэдээлэл сурталчилгааны ажлын хэсэг “Ерөө сумын Онцгой комисс” Файсбүүк хуудсаар дамжуулан иргэдэд 27 төрлийн мэдээ мэдээллийг хүргэн ажиллалаа..

Аймгийн Засаг даргын 2021 оны А/15, сумын Засаг даргын 2021 оны А/11 тоот “Бүх нийтийн ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг эрчимжүүлэх тухай” захирамжийн хүрээнд сумын хэмжээнд 22152 м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.

Онцгой нөхцөл байдалтай холбогдуулан өдрийн хариуцлагатай жижүүрээр 16 албан хаагч, хяналтын постод 31 албан хаагч үүрэг гүйцэтгэж байна.

1. Өглөөний сонсгол мэдээлийн цаг дээр “Хандлага гэж юу вэ?”, “Стресс менежмент”, “Эрүүл хооллолт, идэвхтэй хөдөлгөөн” сэдэвт сургалтуудыг зохион байгуулж давхардсан тоогоор 28 албан хаагч хамрагдсан байна.
2. Төрийн албаны зөвлөлийн сургалт, сурталчилгаа мэдээллийн нэгдсэн сан, Аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан “Сэтгэл хөдлөлөө удирдах нь”, “Албан хаагчдын идэвх оролцоог нэмэгдүүлэх нь”, “Харилцан хүндэтгэл, итгэлцэл бүхий орчин бүрдүүлэх нь” сэдэвт сургалтад давхардсан тоогоор ЗДТГ-ын албан хаагчид, төр, төсвийн байгууллагын дарга, эрхлэгч 21 албан хаагч хамрагдлаа.
3. “Шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ”-ний хүрээнд “Нарийн хөндий”, “Энх тал”-ын 12 айл өрхөд мэдэгдэл хүргүүлэн гарын авлага тараах материал хүргэсэн байна.
4. Эрүүл мэндийн төвөөр үйлчүүлсэн 230 гаруй иргэдэд давсны хэрэглээний талаар мэдээ мэдээлэл олгох үүднээс гарын авлага хүргэлээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг үнэмлэхжүүлэх ажлын хүрээнд сумын хэмжээний 213 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг үнэмлэхжүүлсэн байна.

“Дэлхийн зөн Монгол” Олон Улсын байгууллагаас 1,2-р багийн 0-18 насны зорилтод 139 хүүхдэд буцалтгүй тусламж болох 100.0 төгрөгийг олгосон байна.

Улаанбаатар хотоос болон бусад аймаг, сумаас ирсэн иргэдэд түргэвчилсэн оношлуураар 64 иргэнд, гэрийн тусгаарлалтаас гарсан 76 иргэд PCR шинжилгээнүүдийг тус тус хийж зөөвөрлөсөн байна. Мөн сумын 1-р цэцэрлэгийн 18 багш ажилчид, 162 хүүхдэд эрүүл мэндийн үзлэг, эмнэлгийн ажилчдыг 14 хоногийн 2 дах өдөр бүр PCR шинжилгээнд тус тус хамруулан ажиллаж байна.

Түлээний модны эрхийн бичгийг 20 иргэнд хус 59 м3, нарс 24 м3 нийт 83 м3 түлшний модыг олгосон байна.

Нохой устгалын ажлын хүрээнд 1,2-р багийн 160 золбин нохойг устгаж 2.240.0 төгрөгийн хөрөнгө зарцуулсан байна.

#### **Жавхлант сум:**

Хүний эрхийн Үндэсний комиссоос зохион байгуулсан “Цар тахлын үеийн шийдвэр гаргалт ба хүний эрх” сэдэвт сургалтад төр, төсвийн байгууллагын дарга эрхлэгч нар хамрагдлаа.

“Дэлхийн Зөн Монгол” Олон Улсын байгууллагаас буцалтгүй тусламж болгон 0-18 насны зорилтод 100 өрхийн хүүхдэд буцалтгүй тусламж болох 100.0 төгрөгийг олгосон байна.

“Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”-т зориулан “Миний ээж одонтой ээж” нэвтрүүлэгт 2 багийн нийт 28 ээжийг оролцууллаа. Мөн өдрийн угтан “Цахим соёл-2” аяны хүрээнд Соёлын төвийн орон нутаг сурталчлах танхимаас иргэдийн дунд зохион байгуулсан “ЭЭЖ ТАНЬДАА БАЯРЛАЛАА” цахим мэндчилгээнд 9 иргэн хамрагдсанаас тэргүүн байранд Солонгос улсаас оролцсон Г.Цогбаяр, дэд байранд У.Энхжин, гутгаар байранд Ш.Лхагвасүрэн нар шалгарлаа.



Сумын Засаг даргын баталсан “Хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу “Гамшгаас хамгаалах тухай хууль”, “Эрүүл мэндийн тухай хууль”, “Эрүүл ахуйн тухай хууль”, “Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөллийг бууруулах тухай хууль”, “Хүнсний тухай хууль”, “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль” болон холбогдох дүрэм журам, стандартын хэрэгжилтэд хяналт тавих, ажил үйлчилгээний чанар, стандартын шаардлагыг хангуулах зорилгоор ЕБС, 1-р цэцэрлэг, ЭМТ-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж, үүрэг чиглэл өгч ажилласан.

Голомтот бүс нутгаас ирсэн иргэдийг гэрийн тусгаарлалтад авч PCR-ийн шинжилгээнд хамруулан заавар зөвлөмж өгч ажилласан. Гэрийн тусгаарлалтад нийт 6 иргэн байна. PCR шинжилгээ 26 хүнээс авч аймгийн нэгдсэн эмнэлгийн лабораторит илгээсэн.

Мэргэжлийн байгууллагаас өгсөн зөвлөмжийн дагуу хүн хоорондын зайг баримтлан танхимын багтаамжаас хамаарч нэг анги, бүлэгт хичээллэх хүүхдийн тоо 20 байхаар тооцож, өглөө 1-12 ангийн 221 сурагч, үдээс хойш 1,3,4-р ангийн 49 сурагчид 2 ээлжээр хичээллэж байна. Сургуулийн нийт 42 ажилтан албан хаагчид үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна.

Монгол Улсын Шадар сайдын 2021 оны “Шуурхай штабыг шинэчлэн байгуулах тухай” 22 дугаар тушаалын дагуу сумын Засаг даргын 2021 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн “Шуурхай штабын бүтэц бүрэлдэхүүнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” А/30 дугаар захирамжаар албажуулж, сумын Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн “Сумын Онцгой комиссын бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлах тухай” А/29 дүгээр захирамжаар шинэчлэн байгуулсан.

Сумын Онцгой комисст тус сумын унаган иргэн Д.Мөнхбат гэр бүлийн хамт 2000 ширхэг амны хаалт хандивлалаа.

Малчид, мал бүхий иргэдийн арьс шир, ноос, ноолуурын урамшуулал төсвийн урамшуулалын системээр дамжуулан олгогдох болсонтой холбоотой сумын хэмжээнд урамшуулалд хамрагддаг нийт 310 малчин байна.

Сумын хэмжээнд малчин, мал бүхий иргэдэд 68 гарал үүслийн гэрчилгээ олгосон. Үүнд адууны мах 330 кг, үхрийн мах 5490 кг, хонины мах 1040 кг, ямааны мах 400 кг тус тус олгосон.

### **Зүүнбүрэн сум:**

Сумын Засаг даргын 2021 оны А/22 тоот захирамжаар цаг агаарын дулааралтай холбогдуулан цас ихтэй, уулархаг газар, гуу, жалга, гол, мөрний мөс эрчимтэй хайлж, мөсний нягт багасах үед иргэд явганаар болон тээврийн хэрэгслээр зорчин осолдох, хуурай сайраар шар усны үер буух аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

“Хоггүй цэвэрхэн Зүүнбүрэн” аяныг 03 дугаар сарын 25-наас 04 дүгээр сарын 25-ны хугацаанд сумын Засаг даргын 2021 оны А/23 тоот захирамжаар зарлаж, аяны хүрээнд бүх нийтийн хог цэвэрлэгээг нийтийн эзэмшлийн 80 орчим га талбайд хийж 10 тн хогийг зориулалтын цэгт устгалаа.

Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулж буй төрийн албан хаагчдын чадавхжуулах пүрэв гараг бүрийн сургалтад давхардсан тоогоор 41 албан хаагчдыг хамрууллаа.

Дорнод аймгийн музей, СУИС, Соёл судлалын хүрээлэн, Соёлын өв судлалын сектортой хамтран зохион байгуулсан “Музейн маркетинг ба соёлын өвийн хадгалалт

хамгаалалт” сэдэвт цахим сургалтад орон нутаг судлах танхимын ажилтан хамрагдлаа.

Биеийн тамир спортын газраас зохион байгуулж буй “Эрүүл мэндийн цахим гүйлт 2021” арга хэмжээг иргэдэд цахимаар сурталчлан ажиллаж байна.

“Би эх орны цэрэг” фото зургийн уралдаан зарлаж нийт 45 иргэн оролцож эхний 3 байрыг шалгаруулан шагнаж урамшууллаа. Мөн цэргийн баярыг тохиолдуулан “Эр хүн танаа” цахим концерт бэлтгэн zuunburenzаg, Соёл мэдээллийн төвийн цахим хаягт байршуулж иргэдэд хүргэн ажиллалаа.

Зүүнбүрэн сумын цахим Номын сан болон Зүүнбүрэн Соёл Мэдээллийн төв гэсэн пэйж хуудсаараа дамжуулан Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрөөр “Ээждээ захидал бичээрэй” захидлын уралдаан зохион байгуулж эхний 3 байрыг шагнаж урамшууллаа.

БШУС-ын 2021 оны А/58 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтын “Ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагааг танхимаар зохион байгуулах түр журам”-ын дагуу бэлэн байдлыг ханган, хичээл сургалтын үйл ажиллагааг хэвийн эхлүүлж, 3 ээлжээр хичээллүүлж, цагийн хуваарийн дагуу зохион байгуулалтад оруулаад байна.

12-р ангийн 19 суралцагчийн элсэлтийн ерөнхий шалгалт өгөхөөр бүртгүүлээ. ЭЕШ-тай холбоотой мэдээ, мэдээллээр сурагчдыг хангах зорилгоор сургуулийн коридорт “Мэдээллийн самбар” ажиллуулж, Даваа-Бямба гарагт элсэлтийн ерөнхий шалгалт өгөх сурагчдад 7 төрлийн хичээлээр давтлага зохион байгуулж байна.

Өвчлөлтэй бүс нутгаас ирсэн иргэдийг тусгаарлах журмын дагуу анги удирдсан багш нар ангийн сурагчдын бүртгэлийг хийж тусгаарлалтад байх хугацааны даалгавар зөвлөгөө, зөвлөмжийг өгч ажиллалаа. Нийт 17 сурагч тусгаарлалтад орсон.

Дотуур байрны 25 суралцагчдыг урьдчилсан сэргийлэх үзлэгт хамрууллаа.

МЭҮН-д 757 толгой малыг мал эмнэлгийн үзлэгт хамруулж, халдваргүй өвчний 15 удаагийн дуудлагааар үйлчилгээ үзүүлж цахим бүртгэлд оруулан ажиллалаа. Бэлчир 2 дугаар багт отроор өвөлжсөн Сүхбаатар сумын 8 дугаар багийн иргэн Э.Лхагвагийн 350 толгой бог малд “Оюутсүрэг” МЭҮН –н мал эмнэлгийн үзлэг хийж мал эмнэлгийн цахим гарал үүсэл олгож ажиллалаа. Мөн МЭҮН-ийн мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг сумын нутаг дэвсгэрээс гадагш худалдаалах, хээлтүүлэгт ашиглах, отор нүүдэл хийх болон бусад зорилгоор шилжилт хөдөлгөөн хийх үед олгох цахим гарал үүслийн гэрчилгээг иргэн, аж ахуйн нэгж байгууллагын 2155 кг малын мах, адуу 12, үхэр 31, хонь 52, 1 амьтан, нийт 96 толгой мал, амьтанд, 4700 л сүүнд олгоход хяналт тавин баталгаажуулж ажиллалаа.

#### **Мандал сум:**

Аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан “Нэг баг-Нэг агт” аяны хүрээнд тус сумын иргэн Монгол улсын хошой аварга малчин Г.Ансай, малчин Ж.Баянмөнх, залуу малчин А.Нямдорж, М.Эрдэнэ-Од нар тус бүр нэг адуу хилийн цэрэгт хандивлалаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан “Сэтгэл хөдлөлөө удирдах нь” сэдэвт сургалтад Төрийн үйлчилгээний удирдах 21, төрийн албанд шинээр томилогдсон 10 албан хаагчдыг хамрууллаа.

Сумын Засаг даргын 2021 оны “Зорчих хөдөлгөөнийг түр хязгаарлах тухай” А/55 тоот захирамж, аймгийн Засаг даргын 2021 оны “Бүх нийтийн ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг эрчимжүүлэх тухай” А/15 тоот захирамжийн хэрэгжилтийг

эрчимжүүлэн ариутгал халдваргүйтгэлийг тогтмол хийн, байгууллагын албан хаагчдын бусад аймаг орон нутаг руу зорчих хөдөлгөөнд хязгаарлалт тогтоон, хяналт тавьж ажиллахыг албан байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг болгон ажиллаж байна.

Сумын ЗДТГ-аас Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчидтай хамтран иргэд олон нийт ихээр зорчдог хоолны газар, хүнсний дэлгүүр, зах худалдааны төв нийт 65 аж ахуйн нэгж, иргэдийн Коронавируст халдвар /Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийн мөрдөлт, хоол үйлдвэрлэлийн газруудын халуун боловсруулалтын өрөө, бэлтгэлийн өрөө тасалгаанд хяналтын камер байрлуулсан байдал зэргийг шалгалаа. Шалгалтаар “Хоёр хүү Б”, Тод-1, 2, “Арцат гол”, “Тэмүүн мандал”, “Тэнгэр” хүнсний дэлгүүрүүд, “Хоёр хүү” барааны дэлгүүр, “Samsung” гар утасны дэлгүүр, “Сансар” махны захын зарим ажиллагсад болон гудамж талбайд амны хаалтгүй иргэд их зорчиж байгаа тул зөрчил арилгах талаар үүрэг чиглэл өгч ажиллалаа.

Улсын Онцгой комиссын шийдвэрийн дагуу Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн танхимын хичээл сургалтын үйл ажиллагааг 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхэлсэн ба ерөнхий боловсролын сургуулийн ирц 90,5 хувь, сургуулийн өмнөх боловсролын ирц 62 хувьтай танхимын бус теле хичээлд хамрагдахаар хүсэлтээ цэцэрлэгийн захиргаанд ирүүлсэн 401 хүүхэд буюу 23.2 хувь байна.

Сумын хэмжээнд ерөнхий боловсролын 3 сургуулийн дотуур байранд 143 хүүхдийг эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг баримтлан хүлээн авлаа.

2020-2021 оны хичээлийн жилийн шилдэг илтгэл шалгаруулах уралдааны 2 дугаар шатны шалгаруулалт аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж тус сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн баг хамт олон тэргүүн байранд шалгарч үндэсний хэмжээний хэлэлцүүлэгт оролцохоор боллоо.

Аймгийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд зохион байгуулагдсан “Ардын хувьсгалын 100 жил” шилдэг илтгэлийн уралдаанд 4 дүгээр сургуулийн 12 дугаар ангийн сурагч Д.Өлзийдүүрэн амжилттай оролцож 2 дугаар байранд шалгарлаа.

Орон даяар элсэлтийн ерөнхий шалгалтын бүртгэл эхэлсэнтэй холбогдуулан Боловсролын үнэлгээний төвийн цахим хуудсанд 12 дугаар ангийн сурагчдын хичээл сонголтыг баталгаажуулалт хийгдэж байна. Энэ хичээлийн жилд 303 сурагч төгсөхөөс 270 хүүхэд элсэлтийн ерөнхий шалгалт өгөх урьдчилсан судалгаа гарсан.

Биеийн тамир спортын улсын хорооноос орон даяар зохион байгуулж буй “ЦАХИМ ГҮЙЛТ-2021” уралдаанд тус сумаас 30 гаруй иргэд тусгай аппликэйшнаар дамжуулан оролцлоо.

“Олон Улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан Зүүнхараа хүүхдийн ордноос “Ижийдээ бичсэн миний захидал” цахим уралдааныг 3 насны ангиллаар зохион байгуулж 36 хүүхэд бүтээлээ ирүүлэн оролцлоо. Мөн “Зэвсэгт хүчний 100 жилийн ой”-г тохиолдуулан зохион байгуулсан “Ааваа дуулья” цахим уралдаанд 27 хүүхэд цахимаар оролцсон байна.

“Хараагийн аялгуу 8” яруу найргийн цахим уралдаанд 8 сургуулийн 27 сурагчийн бүтээлээ ирүүлснийг “Сэлэнгэ Мандал Номын сан” цахим хаягаар сурталчилж, шилдэг 4 оролцогчийг шалгаруулан шагнаж, урамшууллаа.

Мөн байгууллагуудын цахим хуудсаар иргэдэд зориулсан ном сурталчилгааны болон танин мэдэхүйн 12 төрлийн 149 төрлийн мэдээлэл нийтэлж, 7388 иргэний хандалттай байна.

Сумын амьжиргаа дэмжих зөвлөл тайлант сард 2 удаа хуралдаж байнгын асаргаа шаардлагатай ахмад настан шинээр 3, сунгалт 2, асрагч солих 1, хөгжлийн

бэрхшээлтэй иргэн шинээр 1, сунгалт 5, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд шинээр 3, сунгалт 4 нийт 19 иргэний өргөдлийг шийдвэрлэв.

“Дэлхийн зөн Монгол” Олон Улсын байгууллагаас хэрэгжүүлж буй зорилтод бүлгийн өрхөд нэг удаагийн мөнгөн тусламж олгох арга хэмжээнд тус сумын 600 өрхийг хамруулахаар судалгааг гарган хүргүүлээд байна.

Тус сумын орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжих 1-р багийн 45, 43, 36-р байрны хойд талын автозамын тохижилтын ажил, Бохир усны насос станцын барилгын 6/04 кв-ын 160 квт дэд станц барих, ЗДТГ-ын 1, 2, 3-р давхрын коридор, өрөө, танхимуудын хана, хаалга, цонхыг засварлах, Зүүнхараа политехник коллежоос спорт сургалтын цогцолбор төвийн уулзвар хүртэлх автозамын хашлага, явган зам барих, бохир усны шугам барих, Хүүхэд залуучуудын соёл спортын цогцолбор төвийн барилгыг үргэлжлүүлэх ажлын нийт 1,298.9 сая төгрөгийн өртөг бүхий нээлттэй 5, тендер шалгаруулалтын онцгой журмаар 1 нийт 6 тендер шалгаруулалтын урилгыг худалдан авах ажиллагааны цахим систем болох tender.gov.mn системд нийтэлж, тендер шалгаруулалтыг эхлүүллээ.

Сумын Засаг 2021 оны “Мал амьтны сэг зэм устгах, орчны цэвэрлэгээ, ариутгал, халдавргүйтгэлийн үйл ажиллагаа зохион байгуулах тухай” А/57 дугаар захирамжийн дагуу нийт 10 үхэр, 6 гахай, 1 нохойн сэгийг устгаж 1900 м<sup>2</sup> талбайд ариутгал, халдваргүйжүүлэлт хийлээ.

Малын шилжилт хөдөлгөөнд байнгын хяналт тавих, малын гоц халдварт өвчин дамжих эрсдэлийг багасгах, малын хулгайтай тэмцэх, мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, гарал үүсэл нь тодорхой, эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүнийг нийтийн хэрэгцээнд нийлүүлэх, мал эмнэлгийн арга хэмжээг технологийн хугацаанд гүйцэтгэж байгаа эсэхэд хяналт тавьж нийт 152 өрхийн 54 толгой адуу, 204 толгой үхэр, 52 хонь, 467 кг адууны мах, 12865 кг үхрийн мах, 5232 хонины мах, 1871 кг ямааны мах, гахай мах 590 кг, 44550 л сүүнд гарал үүслийн гэрчилгээ бичиж олгосон байна.

Мах махан бүтээгдэхүүний мал эмнэлгийн магадлан шинжилгээний QR код олгох ажлыг нэвтрүүлж нийт 34 ширхэг магадлан шинжилгээний гэрчилгээ олголоо.

Талбай тусгаарлалт хийлгэх 7 аж ахуйн нэгж, байгууллага, 3 нөхөрлөл хүсэлт гаргасны дагуу үндсэн ашиглалтын огтлолоор 35 га, цэвэрлэгээний огтлолоор 154 га, цэвэрлэгээний ажлаар 29 га мод бэлтгэлийн талбайд тусгаарлалтын ажил хийгдлээ.

Хэрэглээний мод бэлтгэх эрхийн бичгийг 12 аж ахуйн нэгж, байгууллагад 2322,9м<sup>3</sup>, 1 нөхөрлөлд 25 м<sup>3</sup>, 31 иргэнд нийт 148 м<sup>3</sup> түлээний эрхийн бичиг олгож, 43 ширхэг гарал үүслийн гэрчилгээнд нийт 847,1 м<sup>3</sup> бичиж олгосон.

Тус сумын Түнхэл 5-р багт шар усны үерээс урьдчилан сэргийлэх зорилгоор 3 удаагийн арга хэмжээ зохион байгуулан захирагчийн алба болон 9 аж ахуйн нэгж, байгууллагын 69 иргэн 10 авто машин, 1 ковш дайчлан ажиллаж 41 машин хайрга зөөж 3 хэсэг газарт 265м урт, 0.5-1м өргөн, 0.7-1м өндөртэй жижиг далан байгууллаа.

#### **Орхон сум:**

Аймгийн Засаг даргын 2021 оны “Бүх нийтийн ариутгал, халдавргүйжүүлэлтийн ажлыг эрчимжүүлэх” А/15 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 18 аж ахуйн нэгж, байгууллагын 8636 м<sup>2</sup> талбайд халдавргүйжүүлэлт хийгдсэн.

Сумын “Шуурхай штабыг байгуулах тухай 2020 оны А/15 тоот захирамжийг шинэчлэн 2021 оны А/16 тоот захирамжаар бүтэц бүрэлдэхүүн албадыг шинэчлэн байгуулсан.

Коронавируст халдвар /КОВИД-19/ цар тахалтай холбоотой зөвлөмж, анхааруулга, улс, аймаг, сумын Онцгой комиссын шийдвэр, мэдээ мэдээллийг шторк хэлбэрээр хүргэх ажлыг сумын файсбүүк, цахим хаягуудыг ашиглан иргэдэд хүргэж, халдвартай бүс нутгаас сум дамжин өнгөрч байгаа тээврийн хэрэгслүүдэд наалт наах ажлыг тус тус хийж гүйцэтгэлээ

Коронавируст халдвар илрүүлэх түргэвчилсэн, ПСР-н шинжилгээ хийсэн тоон мэдээ: ПСР /УБ хотоос ирсэн иргэд, эмнэлгийн ажилчид/-143, Түргэвчилсэн-81 иргэнийг шинжилгээнд хамруулсан.

Байнгын 24 цагийн постыг “Бэлэндалай өртөө”-ний гарман дээр байрлуулан Сант сумтай 3 хоногоор ээлжлэн гарч хөдөлгөөнд хяналтыг тавьж байсан бөгөөд 03 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн Орхон сум тус хяналтын постыг хариуцан хөдөлгөөний хязгаарлалтад хяналт тавьж ажиллаж байна.

Төрийн албаны зөвлөлийн сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн газраас төрийн албан хаагчдыг чадавхжуулах зорилгоор долоо хоног бүрийн 4 дэх өдөр тодорхой сэдвийн хүрээнд цахим сургалтыг зохион байгуулдаг. Үүнд давхардсан тоогоор 40 төрийн албан хаагчийг хамруулсан.

Тусламж дэмжлэгээр:

- “Улаан загалмай” ОУБ-аас 8 малчин өрхөд тус бүр 240000 /нийт 1.920.0/
- “Адра” Олон Улсын байгууллагаас малчин өрхүүдэд зудын гамшгийн хариу арга хэмжээний хүрээнд зорилтот 50 малчин өрхөд тус бүр 150.0 /нийт 7.500.0/
- ДЗОУБ-аас хөтөлбөрт хамрагдсан 100 өрхийн хүүхдэд 100.0 төгрөг
- ДЗОУБ-аас “Төгсөлтийн аргачлал” хөтөлбөрт хамрагдсан 30 өрхөд Амьжиргааг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан 800 долларын тоног төхөөрөмж олгохоор шийдвэрлэсэн.

Хүүхэл хамгаалал, хамтарсан багийн чиглэлээр:

- Хүүхдийн сайн сайхны төлөө зөвлөл байгуулагдлаа.
- Хамтарсан багийн төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 68 ажил арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахаар төлөвлөгөөг гарган сумын ИТХ-аар батлууллаа.
- “Гэрээр айлчлагч” хөтөлбөрт 2020 онд хамрагдсан 11 өрхөд хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг ДЗОУБ-д хүргүүлээ.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 08 тоот тогтоолын дагуу Орхон сум Баруунбүрэн сумаас түлшний зориулалтаар 2000 м3 шинэс мод, өөрийн сумаас 50 м3 бургас бэлтгэх хуваарь батлагдсан. Баруунбүрэн сумаас 31 иргэн 124 м3 түлшний мод, 20 иргэн 40 м3 гишүү бэлтгэж тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавин ажиллалаа.

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 05 тоот тогтоол, сумын Засаг даргын 2021 оны А/14 тоот “Бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулах тухай” захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд сумын хэмжээнд нийтийн эзэмшлийн гудамж талбай, засмал зам дагуух хог хаягдлыг цэвэрлэсэн. Тус ажлын хүрээнд 8 төрийн болон төрийн бус байгууллагын 75 албан хаагч, ажилчид 11 га газрын 6 тн ил задгай хог хаягдлыг цэвэрлэн сумын төвийн төвлөрсөн хогийн цэгт ачиж буулгах ажлыг зохион байгуулсан.

#### **Орхонтуул сум:**

Аймаг, сумын Засаг даргын 2021 оны “Бүх нийтийн ариутгал халдваргүйжүүлэлтийг эрчимжүүлэх тухай” А/15, А/04 дүгээр захирамжийн хэрэгжилтийг ханган 7 хоног бүрийн 5 дахь өдрүүдэд сумын хэмжээнд ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг хийж байна. 03 дугаар сард сум, тосгоны хэмжээнд халдвар хамгааллын дэглэмийг баримтлан нийт 47 байгууллагын 24564 м2 талбайд

ариутгал халдваргүйтлийг хийлээ. Мөн орон сууц болон гэр хорооллын айл өрх бүрийг хамруулан орон сууц, орон сууцны орц хонгил, нийтийн эзэмшлийн талбайг ариутгал халдваргүйжүүлэлтэд бүрэн хамрууллаа.

Сумын Онцгой комиссоос суманд ирж буй болон гарч буй иргэдийн PCR шинжилгээний хариу, бичиг баримтыг хянан шалгах “Шалган нэвтрүүлэх баг”-ийг тогтмол ажиллуулж байна. Сумын хэмжээнд 22 өрхийн 37 иргэн, түүний хамаарал бүхий 40 иргэн нийт 77 иргэнийг 7хоногийн гэрийн тусгаарлалтад авч, хяналт тавин ажиллаж байна.

Худалдаа үйлчилгээ, хүнсний дэлгүүрүүдийн үйл ажиллагаанд шуурхай штабын жижүүрүүд өдөр бүр хяналт тавьж, худалдагчид болон үйлчлүүлж байгаа иргэдэд сумын Онцгой комиссоос заавар, зөвлөмж өгч зарим тохиолдолд шаардлага тавин ажиллаж байна.

Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа хүнсний дэлгүүрүүд, хоолны газруудад Коронавируст халдварын үед дагаж мөрдөх түр журмын хэрэгжилтийг хангуулах зорилгоор хяналт шалгалтын ажлыг хийлээ.

ХХААХҮ-ийн сайдын 2021 оны 01 тоот албан даалгаврын хэрэгжилтийг хангах, аймгийн ХХААГ-ын даргын 2021 оны 73 тоот ажлын чиглэлийн дагуу 03 дугаар сарын 15-17-ны өдөр сумын Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг отрын малчдаар явж 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор нутаг чөлөөлөх албан мэдэгдэл хүргүүлэн ажилласан.

Сумын хэмжээнд 1-р улирлын байдлаар адуу 19, үхэр 13, хонь 38, ямаа 60 нийт 130 толгой мал зүй бусаар хорогдоод байна.

Мал төллөлт:

- Төллөлтийн хувь 57 хувь
- Бойжилтын хувь 98,9 хувьтай байна.

Тус сард нийт 44 цахим гарал үүслийн гэрчилгээнд хяналт тавьж баталгаажуулсан байна. Амьдаар адуу 24, үхэр 76, хонь 42, ямаа 33 нийт 175 мал амьтан хүнсний зориулалтаар бичигдсэн байна. Бүтээгдэхүүн үйлдвэрлэл худалдаа, хүнсний зориулалтаар адуу 150 кг, үхрийн мах 388 кг, хонины мах 940 кг, ямааны мах 774 кг, гахай маханд 300 кг маханд, сүү 30 л, аарц 30 л, цахим гэрчилгээ бичигдсэн байна.

#### **Сайхан сум:**

Хичээл сургалтын үйл ажиллагаа эхэлсэнтэй холбогдуулан сургууль, цэцэрлэгүүдийн бэлтгэл бэлэн байдлыг шалгаж, хяналт тавьж ажилласан ба хөл хориог тогтоох, гэрийн ажиглалтад байгаа иргэдийг хянах үүднээс 13 аж ахуй нэгж, байгууллагын ажилтан албан хаагчдыг сумын хэмжээнд хөдөлгөөнт болон нийтийн эргүүлд хуваарийн дагуу ажиллуулж байна.

Авто замын шалган нэвтрүүлэх постны хэвийн үйл ажиллагааг ханган хяналт шалгалтыг чангатгах, ширээ нуруугаар болон хулгайн замаар орж ирэх, болзошгүй эрсдэлээс хамгаалах зорилгоор Номгон тосгонд нэмэлтээр хөдөлгөөнт постын байрлуулах ажлыг “Хойд сэртэн” харуул хамгаалалтын албатай хамтран зохион байгуулан ажиллаж байна.

Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төр төсвийн болон хувийн аж ахуй нэгж байгууллагуудад албан тоот хүргүүлэн, сумын Онцгой комисс, Шуурхай штабтай хамтран ажиллах, өдөр бүр ариутгал, халдваргүйтгэл хийх зэрэг арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болгоод байна.

Сумын хэмжээнд иргэдэд хог хаягдлын тухай хууль сурталчлах, санамж, зөвлөмж 250 ширхгийг бэлтгэн сурталчилж ажиллав.

Гамшгийн үеийн бэлтгэл бэлэн байдлыг хангах зорилгоор нийт 11 байгууллагын ажилтан албан хаагчдын хамруулан гамшгаас хамгаалах алба мэргэжлийн ангиудын мэдлэг, дадлага чадвар, үйл ажиллагааны бэлэн байдлыг хангуулах үзлэг сургуулилтыг зохион байгуулав.

Олон Улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан сумын хэмжээнд тус өдөр албан үүргээ гүйцэтгэн ажиллаж буй эмэгтэй албан хаагчдад мэндчилгээ дэвшүүлж, хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгуулав.

Байгаль орчны хяналтын чиглэлээр сум дундын Цагдаагийн хэлтэстэй хамтран төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2 удаа, төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 2 удаа тус тус зохион байгуулж ажилласан. Хяналт шалгалтын хүрээнд эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй газрын хэвлий ашигласан 2 иргэнд “Зөрчлийн тухай хууль”-ийн дагуу нийт 300.0 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан.

Хууль бус мод бэлтгэсэн 1 иргэнд сум дундын Цагдаагийн хэлтсээс эрүүгийн хэрэг нээн шалгаж байгаа хэрэгт, шинжээчээр ажиллаж Ойн санд учруулсан 680.000 төгрөгийн хохирол нөхөн төлбөр тооцсон Улсын байцаагчийн дүгнэлт гарган ажилласан.

Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох Засгийн газрын 2013 оны 394 дүгээр тогтоолын дагуу сумын нийт 170 малчин, мал бүхий иргэний 15930 арьс, шир буюу 489 ширхэг паданыг ARIS программд шивж, холбогдох материалыг аймгийн ХХААГ хүргүүлж ажилласан.

Сумын малын тоонд адуу 5369, үхэр 13437, хонь 54356, ямаа 46842 нийт 120004 тоологдсон ба өмнөх онтой харьцуулахад адуу 224, үхэр 1098, хонь 7542, ямаа 6100-аар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/57 тоот захирамжийн дагуу зарим байгууллага, үйлчилгээний газруудын үйл ажиллагааг нээж, хичээл сургалтын үйл ажиллагаа эхэлсэнтэй холбогдуулан нийт 21 байгууллагын 24480 м<sup>2</sup> талбайд ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэлээ. Сумын өндөржүүлсэн бэлэн байдлын хорио цээрийн үед аж ахуй нэгж, байгууллагуудаар тогтмол өдөр тутмын ариутгал халдваргүйжүүлэлтийг хийлгэж, томоохон эрсдэл өндөртэй 10 байгууллагын 211429,5 м<sup>2</sup> талбайд ариутгаж ажиллалаа.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны 01/109 албан тоотын дагуу автомашин, дугуй засвар, машин угаалгын нийт 4 байгууллагаар халдвар хамгааллын дэглэм муу байгаагаас зөрчилтэй холбоотой үзлэг шалгалт хийж, газар дээр нь зарим зөрчлийг арилгуулж ажиллав.

Сумын хэмжээнд худалдаа үйлчилгээ явуулж бизнес эрхэлж буй 134 аж ахуйн нэгж, байгууллага, иргэн байгаа бөгөөд сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээг 50 байгууллага, иргэнтэй байгууллаа. Тус гэрээнд ажлаа тайлагнаж, үр дүнтэй ажиллах, сумын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, нийтийг хамарсан ажил, арга хэмжээнд хамтран ажиллах болон ариутгал, халдваргүйжүүлэлт тогтмол хийх талаар тусгагдсан

Сайхан сумын 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу цахим тендер шалгаруулалтын үнэлгээний хороо 14 тендерийн баримт бичгийг боловсруулан цахим тендерийг зарлан, урилгыг [tender.gov.mn](http://tender.gov.mn) сайт болон олон нийтийн цахим сүлжээнд нийтэлсэн. Тендерүүд хугацаандаа нээгдэж, нээлтийн тэмдэглэл хөтлөн,

үнэлгээний хороог хуралдуулж, гарсан шийдвэрийн дагуу эрх байгуулах мэдэгдлийг хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

- Төр төсвийн байгууллагын шатахуун нийлүүлэх 4 тендер амжилттай зохион байгуулагдаж, шалгарсан байгууллагад гэрээ байгуулах эрх олгосон.
- ЗДТГ-ын 1 давхрын өргөтгөл худалдан авах тендер оролцогч байгууллага байхгүйн улмаас амжилтгүй болсон тул дахин зарласан.
- Номгон 3-р багийн нутаг дэвсгэрт бэлчээрийн гүний худаг гаргах ажлын тендер зарлагдаж оролцогчгүйн улмаас амжилтгүй болсон тул дахин зарласан.
- 2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах “Залуучууд хөгжлийн ордон”-ы барилгын зураг төсөв хийх ажлын даалгавар бэлтгэн, анхан шатны эскиз зургийг мэргэжлийн байгууллагаар гаргуулан ажилласан.
- ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар Бичил хорооллуудын дунд тохижилтын ажил хийгдэхээр тендерийн бэлтгэл ажил хийгдэж байна. Зураг төсвийн мэргэжлийн байгууллагатай холбогдон шаардлагатай зураг мэдээллээр ханган ажиллаж байна.

Олон Улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт зориулан “Аз жаргалын цэцэг” цахим контент, Монгол Улсад орчин цагийн “Зэвсэгт хүчин үүсгэн байгуулагдсаны түүхт 100-н жилийн ой”-д зориулан “Байлдагч тандаа талархъя” хүндэтгэлийн тоглолтыг тус тус зохион байгуулж, гэрээр ном олголтоор 9 иргэнд 13 ном, товхимлоор үйлчилж ажилласан байна.

СӨБ-ын хүүхдүүдийн дунд “Ээждээ барих бидний бэлэг” гар зургийн уралдааныг зохион байгуулав.

2020-2021 оны хичээлийн жилийн “Танхимын болон цахим сургалтын хэрэгжилт” сэдэвт Орхон бүсийн сургууль, цэцэрлэгийн багш нарын оны шилдэг илтгэл шалгаруулах онлайн уралдааныг зохион байгуулж, нийт 18 баг оролцсоноос ЕБ-ын 1-р сургуулийн баг 1-р байр, ЕБ-ын 2-р сургуулийн баг 2-р байр, Орхон цэцэрлэгийн баг 3-р байрыг тус тус эзэллээ.

Олон Улсад хүлээн зөвшөөрөгдсөн “SDQ” аргачлалын дагуу сэтгэл зүйн тулгамдсан асуудал, зөн төлөвийн эрсдэл, хэт хөдөлгөөнтэй байдал, үе тэнгийн дарамт зэрэг 4 төрлийн түгшүүрийг тодорхойлдог судалгаагаар 1-12-р ангийн нийт сурагчдыг 100 хувь хамруулан оношлох ажлыг зохион байгуулсан байна.

Сайхан сумын 1,2,3-р цэцэрлэгийн нийт 535 хүүхдийн үзлэг, шинжилгээг цэцэрлэг тус бүр дээр халдвар хамгааллын дэглэм баримтлан зохион байгуулсан.

Улаанбаатар болон бусад орон нутгаас 3 сард 133 хүн ирж бүртгэгдэн гэрийн тусгаарлалтад эмнэл зүйн асуумжийн дагуу хянагдсанаас 61 хүнд ПГУ-н шинжилгээ авч ажилласан байна.

Сумын нийт ард иргэдийн дунд цахим сүлжээнд давсны хэрэглээний тухай тандалт судалгааг 11 асуумжийн дагуу явуулж судалгааг дүгнэн зөвлөмж гарын авлага бэлтгэн сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг цайны газар болон зоогийн газартхүргүүлж, мөн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа, амбулаторийн тасгаар үйлчлүүлж байгаа иргэдэд давсны зохистой хэрэглээний талаар мэдээлэл түгээж гарын авлага танилцуулсан байна.

Тус сумын Хот тохижилтын газар нь улс, аймгийн Онцгой комиссоос ирүүлсэн чиглэлийн дагуу 7 хоног бүрийн баасан гарагт нийтийн эзэмшлийн талбай хүүхдийн тоглоомын талбайд ариутгал халдваргүйтгэл хийж нийт талбай тус бүр Тоглоом 2664 м<sup>2</sup> нийтийн эзэмшлийн 1,6 км зам, ногоон байгууламжийн 8898.1 м<sup>2</sup> конторын ажилчдын өрөө 440 м<sup>2</sup> нийт 11602 м<sup>2</sup> талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийж ажиллаж байна. Мөн нийтийн эзэмшлийн талбайд байрлах 317 ширхэг Улиас модны



хэлбэржүүлэх ажлыг 100 хувь хийж гүйцэтгэсэн ба хаврын эхэн сард жил бүр хийгддэг нийтийн цэвэрлэгээ үйлчилгээг хогийн цэгийн ойр орчим гуу жалгын 3 талын 200 метр газрыг цэвэрлэж, гялгар уутыг түүж шатаасан байна.

Орон сууц болон гэр хорооллын хог тээвэрлэлт, захиалгатай албан газар, аж ахуйн нэгжүүд, айл өрхүүдээс хуваарийн дагуу ачилт хийж, 03 дугаар сард нийт 114 удаагийн ачилтаар 314 тн хог хаягдлыг нэгдсэн цэгт хаях ажлыг хийсэн.

#### **Сант сум:**

2021 онд хаврын тариалалтад шаардагдах үр, бордоо, ургамал хамгаалах бодисын захиалга авч дутагдах үр 754 тн, үр ариутгагч тебутин 170 тн, ургамал хамгааллын бодис алмазис 40 кг, фенизан 661 л, пумасупер 3130 л, раундап 4940 л, нийлмэл бордоо 101 тн, азотын бордоо 32 тн, эдагум 1850 литрийг тус тус захиалсан байна.

Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2015 оны А/105 дугаар тушаал “Ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журам”-ын дагуу сумаас гадагшаа гарч байгаа 5 удаагийн тээвэрлэлтийн 6.5 тн хүнсний ногоо, 24.6 тн ногоон тэжээлд гарал үүслийн гэрчилгээ олгож ажиллалаа.

Хаврын тариалалтын ажил эхлэх гэж байгаатай холбогдуулан Улаанбаатар хот болон бусад орон нутгаас суманд ирж ажиллах иргэдийн судалгааг гаргахад Улаанбаатар хотоос 6 аж ахуйн нэгжид нийт 39 иргэн, орон нутгаас 2 аж ахуйн нэгжид 5 иргэн ирэхээр бүртгүүлсэн байна.

Сумын хэмжээнд үхэр сүргийг ээмэгжүүлэх, бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд үхэртэй өрхийн судалгааг гаргаж, 378 өрхийн 12738 үхэр байгаагийн 135 нь бух, 5258 нь хээлтэгч байгаа бөгөөд энэ оны төлийг нэмээд 18026 үхэр ээмэглэхээр байна. Бухын үзлэг хийх технологит ажлын бэлтгэлийг ханган нийт бухтай өрхийн судалгааг хийлээ. Сумын дүнгээр 210 бухтай байхаас 135 бух байна. Бухын хүрэлцээ хангамж 64 хувьтай байна.

Сумын хэмжээнд 03 дугаар сарын байдлаар мал төллөлт 39,4 хувьтай, том малын хорогдол 0,003 хувьтай байна.

Сумын Засаг даргын 2021 оны “Бүх нийтийн хог цэвэрлэгээ зохион байгуулах тухай” А/28 тоот захирамжийн дагуу бүх нийтийн хог цэвэрлэгээг зохион байгуулж, төсвийн 5 байгууллагын 63 албан хаагч оролцож 48 м3 хог, аж ахуйн нэгжүүдээс 24 хүн оролцож 10 м3 хог, айл өрхүүдээс 118 хүн оролцож 111 м3 хог цэвэрлэлээ.

Сумын Засаг даргын 2021 оны “Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг байгуулах тухай” А/15 дугаар захирамжаар ой хээрийн түймрийн үед ажиллах гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийн бие бүрэлдэхүүнийг шинэчилж 16 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, бие бүрэлдэхүүний бэлэн байдлыг хангах дадлага сургуулилтыг туршилтын журмаар зохион байгууллаа. Энэ ажлын хүрээнд ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх санамж зөвлөгөөг 28 иргэнд өглөө.

Баруунбүрэн сум дахь Орхон бүсийн сум дундын ойн анги мэргэжлийн байгууллагатай хамтран Тэлдийн Халзан уулын ард, Баянзүрх уулын энгэрт хэрэглээний мод бэлтгэх талбай тусгаарлалтын ажлыг хийлээ.

Сумын Засаг даргын 2021 оны А/25 тоот захирамжаар “Коронавируст халдварын эсрэг вакцинаар дархлаажуулалтын ажлыг суманд зохион байгуулах” ажлын хэсгийг ЗДТГ-ын даргаар ахлуулан 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж ажил үүргийн хуваарийг баталсан.

Сумын Засаг даргын 2021 оны А/31 тоот захирамжаар Ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийн ур чадварыг үнэлж дүгнэх ажлын хэсгийг

төрийн байгууллага, сургууль цэцэрлэгийн удирдах зөвлөл, эцэг эх, олон нийтийн төлөөлөл 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгууллаа.

Сумын хэмжээнд хараа хяналтгүй уралдаан сунгаа, үсэргээ хийх эрсдэлтэй байгаа тул Засгийн газрын 2019 оны 57 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд сумын Засаг даргын 2021 оны “Уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг хангах, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх тухай” албан тоотыг “Сан буурал” морин спорт уяачдын холбоо, Ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт тус тус хүргүүллээ. “Дэлхийн Зөн Монгол” ОУБ-аас “Ковид-19” цар тахлын халдварын үед хүнсний тусламж үзүүлэх 100 өрхийг сумын “Хүүхдийн сайн сайхны төлөө зөвлөл”-ийн 2 дугаар хуралдааны шийдвэрийг үндэслэн сонгон авч өрх тус бүрт 100.0 төгрөгийн хүнсний тусламж үзүүлэх гэрээг хийлээ.

Сумын Соёлын төв, Эмэгтэйчүүдийн холбоотой хамтран Олон Улсын эмэгтэйчүүдийн эрхийн өдрийн угтан “Ээжийн бүүвэйтэй хорвоо” цахим дууны уралдааныг зохион байгуулж 9 иргэн оролцлоо. Мөн цахим мэндчилгээний уралдааныг зохион байгуулж нийт 18 иргэн оролцов.

Залуу яруу найрагч Цэрэнхүүгийн Цэлмэгийн нэрэмжит яруу найргийн наадамд цэцэрлэгийн насанд 9 хүүхэд, 6-9-р ангийн сурагчдын дундах уралдаанд 18 сурагч нийт 26 хүүхэд хамрагдан оролцож байна.

Иргэдийг соён гэгээрүүлэх ажлын хүрээнд цахим орчинд эерэг хандлага төрүүлэх зорилгоор “Мөнхөд дуурсагдах алдартнууд” цуврал цахим танилцуулгын ажлыг зохион байгуулж нийт 24 ахмад настанг алдаршуулах ажлыг зохион байгуулж нийт 54800 иргэний хандалт авсан байна.

#### **Сүхбаатар сум:**

Сүхбаатар суманд Коронавируст халдвар /Ковид-19/-ын сэжигтэй тохиолдол илэрсэнтэй холбогдуулан цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах тухай сумын Засаг даргын “Зарим үйл ажиллагаа түр хугацаанд зогсоож, хязгаарлах тухай” А/60 тоот захирамж гарлаа.

03 дугаар сарын 24-ний өглөөний 07:00 цагаас 03 дугаар сарын 27-ны өглөөний 07:00 цаг хүртэл хугацаанд сумын хэмжээнд эмийн сан, шатахуун түгээх станц, ус, дулаан, цахилгаан хангамж, банк, хүнс үйлдвэрлэл, хүнсний дэлгүүрээс бусад аж ахуйн нэгж, байгууллага, сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа болон сум доторх тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнийг зогсоож, иргэд, олон нийтийг хамарсан үйл ажиллагаа явуулах, архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг тус тус хориглолоо.

Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа хүнсний худалдааны газруудын үйл ажиллагаа эрхлэх цагийн хуваарийг 2021 оны 03 дугаар сарын 24-27-ны өдрүүдэд 08:00-20:00 цаг хүртэл хугацаанд ажиллуулахаар тогтоож, халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан ажиллах талаар аж ахуйн нэгж байгууллагуудад заавар зөвлөгөө өгөн хяналт тавин ажиллаж байна.

Байгууллагын нийт албан хаагчдын 15 хүртэл хувийг томилгоожуулан халдвар хамгааллын дэглэмийг баримтлан ажиллаж байна.

2021 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар Номин буудлын тусгаарлах ажиглалтын байранд 33 иргэн, Сэлэнгэ зочид буудлын тусгаарлах ажиглалтын байранд 1 иргэн, нийт 2 байранд 34 иргэн тусгаарлагдаж байна. Мөн тусгаарлах ажиглалтын 1 байранд нийт 1 эмч, сувилагч ажиллаж байна.

Халдвартай бүс нутгаас ирж гэрийн тусгаарлалтад байгаа иргэдээс Эрүүл мэндийн газартай хамтран 3 чиглэлд ПСР шинжилгээнд 8 багийн 62 иргэнийг

хамруулахаас 55 иргэнийг шинжилгээнд хамруулан 88,7 хувийн гүйцэтгэлтэй ажиллалаа.

Хөдөлгөөний хязгаарлалттай холбоотойгоор Сүхбаатар сумын хэмжээнд хяналтын 13 цэгүүдэд 52 алба хаагч, 8 хөдөлгөөнт эргүүлийн цэгт 16 албан хаагч ажиллан иргэдийн хөдөлгөөнийг хяналт тавьж байна.

Тус суманд 03 дугаар сарын байдлаар Голомттой бүс нутгаас хүндэтгэн үзэх шалтгаантай 9 тээврийн хэрэгслээр 31 иргэнийг халдвар хамгааллын дэглэм сахиулан бүртгэлжүүлэн нэвтрүүлж багийн Засаг дарга нарын хяналтад гэрийн тусгаарлалтад шилжүүлэн хяналт тавин ажиллаж байна.

Улаанбаатар хотоос ирж буй Сүхбаатар сумын харьяатай нийт 121 иргэний хүсэлтийг <https://forms.gle/bFRaPmvKQcQG4BX47> холбоосоор бүртгээд байна. Үүнд: нийтийн тээврээр 62 иргэн, хувийн унаагаар 59 иргэн ирэх хүсэлт гаргалаа.

Улаанбаатар хотоос хүнс тээвэрлэн ирж буй 12 тээврийн хэрэгслийн ачаа сэлгэн буулгахад хяналт тавьж ажиллаж, ачаа тээвэрлэн ирсэн тус сумын харьяа 7 жолоочийг багийн Засаг дарга нар гэрийн ажиглалт тусгаарлалтад авч ажиллаж байна.

Төрийн албаны зөвлөлийн сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн газраас төрийн албан хаагчдыг чадавхжуулах зорилгоор 7 хоног бүрийн 4 дэх өдөр зохион байгуулж байгаа 4 удаагийн цахим сургалтад ЗДТГ-ын болон харьяа төр төсвийн байгууллагын нийт давхардсан тоогоор 85 албан хаагч сургалтад хамрагдлаа.

Сум дундын шүүхээр хорих ял эдлэх шийтгэлтэй иргэний 2 хүүхдэд хуулийн дагуу асран хамгаалагч тогтоолоо.

2021 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх “Сүхбаатар сумын алслагдсан багуудад хог тээврийн автомашин” худалдан авах нээлттэй тендер шалгаруулах үнэлгээний хороог байгуулж уг машиныг худалдан авах нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг төрийн худалдан авах ажиллагааны цахим системд нийтлээд байна.

Коронавируст халдварын улмаас хойшлогдсон 2020 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх байсан Салхит 3-р багт гэрэлтүүлэг хийх “Цас эрчис” ХХК-ий ажлын гэрээг сунгаж, ажлын 90 хувьтай гүйцэтгүүлж нийт санхүүжилтийн 50 хувийг гүйцэтгэгч компанид олгоод байна. Мөн Коронавируст халдварын улмаас хойшлогдсон 2020 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх байсан Хонгорморьт 1-р багт тоглоомын талбайн тохижилт хийх “Хүчит Сэлэнгэ” ХХК-ий ажлын гэрээг сунгаад байна.

“Мөс цөмрөх аюулаас урьдчилан сэргийлэх” нэгдсэн арга хэмжээний хүрээнд тус сумын 8 багийн иргэдэд гол мөрөн, нуурын мөсөнд цөмрөх аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр цахимаар сэрэмжлүүлэг хүргэж, Орхон-Сэлэнгийн бэлчир, Орхон, Буурын голуудын гарам, гарц, Хөдөө нуур зэрэг малчид, тээвэрчид, иргэд ихээр зорчдог газруудаар хяналт шалгалт хийж зөвлөмж, санамж өгч ажиллалаа.

Сүхбаатар сумын авто засвар, дугуй засварын үйлчилгээ үзүүлдэг 13 аж ахуйн нэгж, байгууллагуудаар халдварын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар танилцуулан хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж зөрчил илэрсэн албан байгууллагад зөрчил арилгах 7 хоногийн хугацааг өгч зөрчлийг арилгуулан ажиллалаа.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/70 тоот захирамжийн хэрэгжилтийг ханган Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сэрэмжлүүлэг мэдээ, сурталчилгааг сумын Байгаль орчны самбар болон Сүхбаатар сумын цахим хуудсаар дамжуулан иргэдэд өдөр бүр хүргэн ажиллаж байна. Мөн аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны 31/87 тоот албан бичгийн дагуу шар усны үерийн аюулаас урьдчилан

сэргийлэх мэдээг Сүхбаатар сумын цахим хуудсаар өдөр бүр иргэдэд хүргэн, тус сумын 8 багийн дарга нартай хамтран зохион байгуулан ажиллаж байна.

Сумын хэмжээнд нийт 10334 мал төллөхөөс 8663 мал төллөөд байна. Үүнээс гүү 622, үнэ 1783, хонь 2681, ямаа 3577 байна.

#### **Түшиг сум:**

Коронавируст халдвар “Ковид-19” өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн байгууллагууд буюу Соёлын төв, Засаг даргын Тамгын газрын албан хаагчид дээд шатны байгууллагаас үүрэг даалгаврын хүрээнд өдөр бүр “шуурхай штаб дээр 2 албан, үзүүр хошууны постонд мөн 2 албан хаагч 24 цагаар ажиллаж сумаас гарах хөдөлгөөн болон аймаг орон нутгаас ирэх хөдөлгөөнд хяналт тавьж, хүндэтгэн үзэх шалтгаантай иргэдийг холбогдох бичиг баримтыг шалган, халдвар хамгааллын дэглэмийг сайтар сахиулан зөвшөөрөл олгож, нэвтрүүлж байна.

2021 оны мод бэлтгэх хуваарийн дагуу “Шинэ бадрах” ХХК Хар горхид-3 талбай, УБТЗ-ын “Мод боловсруулах үйлдвэр” “Ар шүрэн”-д цэвэрлэгээний огтлолоор 1 талбай, “Мойлт нуга” ХХК 2 талбайд тус бүр мод бэлтгэх талбайг тусгаарлалт хийж ажиллалаа.

УБТЗ-ын “Мод боловсруулах үйлдвэр”-ийн мод бэлтгэл тээвэрлэлтэд хяналт тавьж 1900 м3 хэрэглээний модыг тээвэрлэх ажилд өдөр бүр хяналт тавьж ажиллаж, модны хуваарийн дагуу мод бэлтгэлээ дууслаа. Хэрэглээний зориулалттай мод худалдан авах 59 иргэний 750 м3 мод хүссэн саналыг хүлээн авч 20 иргэнд хөнгөлөлттэй үнээр хэрэглээний мод УБТЗ МБҮ-ээс олгуулсан. Мөн сумын ЗДТГ, СМТ 26 тэвш, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй зорилтот бүлгийн 30 айл өрхөд түлээний мод үнэ төлбөргүй олгосон.

“ОУ-ын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”-т зориулан “Ээжээ дуулах дуу” цахим дууны уралдаанд нийт 8 оролцогч оролцож гурван байр шалгаруулсан. Мөн “Цэцэгт мэндчилгээ” арга хэмжээг зохион байгуулж нийт 68 ээжүүд болон эмэгтэйчүүдэд цэцэгт мэндчилгээг хүргэж ажиллалаа.

Монгол цэргийн өдөрт зориулан “Энхийн манаанд-Цэрэг миний бахархал” сэдэвт тоглолтыг соёлын төвийн ажилтан албан хаагчид болон дугуйлангийн сурагчид цахимаар зохион байгууллаа.

Түшиг сумын хэмжээнд 30 хоногийн хүнстэй байна. Сумын хэмжээнд 35 ширхэг шуудай хорголжин нийт 28 өрхөд, малын тэжээл нэн шаардлагатай байгаа 8 өрхөд 10 ширхэг шуудайтай тэжээлийн будаа тараасан. сумын малчин иргэд болон мал бүхий иргэдэд хүсэлтийг үндэслэн 83 өрхөд 20.5 тн тэжээл тараасан.

Сумын хэмжээнд том малын зүй бүс хорогдол 1471 үүнээс адуу 22, үхэр 85, хонь 977, ямаа 387 байна.

Жаргалмандах 1-р баг болон Ар нуга 2-р багийн хөдөөгийн малчин нийт 46 өрхөөр явж төлийн мэдээ болон хорогдлын мэдээ авсан бөгөөд иргэдээс өргөдөл, гомдол, саналыг хүлээн авч холбогдох мэргэжилтэнд хүргүүлж, шинээр батлагдаж байгаа хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг танилцуулж ажиллалаа. Мөн шар усны үертэй холбогдуулан сэрэмжлүүлэг, зөвлөмж гарган айл өрхүүдэд тараан мэдээлэл өгч байна.

#### **Хушаат сум:**

Сумын Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 4 жилийн төлөвлөгөөг боловсруулах ажил хийгдэж байна. Төрийн Албаны Зөвлөлөөс зохион байгуулсан 4 цуврал сургалтад төрийн албан хаагчдыг хамрууллаа.

“Тариалангийн бүс нутагт мал аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлж, газар тариалантай хослуулах нь” уулзалт ярилцлагыг нутгийн захиргааны удирдлага, газар тариалан эрхлэгчид, эрчимжсэн аж ахуй эрхлэгч малчдын төлөөлөл 10 хүнийг хамруулан зохион байгуулж мал сүргийн бүтцийг адуу 5 хувь, үхэр 50 хувь, хонь 35 хувь, ямаа 10 тус тус эзлэх, эрчимжсэн болон хагас эрчимжсэн аж ахуйгаас бусад малчин өрхийн малын тооны хязгаарыг 500 малаас дээшгүй байх зэрэг 4 саналыг аймгийн ХХААГ-ын урт хугацааны бодлогын баримт бичигт тусгуулахаар хүргүүлээ.

Сумын Онцгой комиссын хурлыг 2 удаа хуралдаж хөдөлгөөний хязгаарлалт тогтоох, хязгаарлалтын хугацааг сунгах чиглэлээр 2 захирамж гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Сумын 1-р цэцэрлэг нь 03 дугаар сарын 01-нээс эхлэн хичээл, сургалтын үйл ажиллагааг танхимаар эхлүүлэхтэй холбогдон гарсан БШУЯ-ны А/58 түр журмын дагуу ариутгал цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг заавар, зөвлөгөө, төлөвлөгөөний дагуу хийж үйл ажиллагаа хэвийн явагдсан. Танхимаар-78 хүүхэд, цахимаар-26 судалгааг гарсан. Хамран сургалт ирвэл зохих 2200 хүүхдээс ирсэн 1484 хамрагдан хамрагдалт 68 хувьтай байна.

Аймгийн Нийтийн номын сангаас “Орчин цагийн Зэвсэгт хүчин байгуулагдсаны 100 жилийн ой”-г тохиолдуулан зохион байгуулсан “Цахим гар зургийн уралдаан”-д сургуулийн 8а ангийн сурагч Х.Чингүүн “Тэргүүн” байр эзэлсэн.

Сумын Соёлын төвөөс “Олон Улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”-өөр сумын Эмэгтэйчүүдийн Зөвлөлөөс “Дархан ээж”, “Ачлалт ээж”, “Дархан бэр”, “Уран бэр”, “Манлай малчин” хүндэт тэмдэг гардуулах хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгууллаа. Мөн цахимаар “Ээждээ захидал бичээрэй” уралдааныг зарлаж 1,2,3-р байр эзэлсэн сурагчдад өргөмжлөл, мөнгөн шагналаар шагналаа.

Халдвар, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хорогдсон малын хүүр сэг зэм устгах ажлыг зохион байгуулж 1 үхэр, 5 хонь, 6 ямаа, 40 нохойны хүүр сэг зэмийг цуглуулан устгаж, устгасан цэгийн 50 м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийж ажилласан.

#### **Хүдэр сум:**

Сумын Засаг даргын зөвлөлийн хурал нэг удаа болж цаг үеийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж ажиллаа. Үүнд:

1. Шар усны үерээс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах, үерийн усны хоолой байрлуулах зураг гаргах
2. Аймгийн засаг даргын Зөрчил арилгуулах тухай албан тоотын хэрэгжилтийн явц
3. Сумын ЗДТГазар, Ойн анги ОНӨААТҮГ, Хүдэр тохижилт ОНӨААТҮГ-ын эд хөрөнгийн тооллого зохион байгуулах
4. Хөрөнгө оруулалтын ажлын хугацааг тодорхой зааж хугацаанд нь явуулах
5. 50 жилийн Ой тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсэг томилох
6. Албан хаагчдын цагийн бүртгэлийг сайжруулах зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Албан хаагчдын идэвх оролцоог нэмэгдүүлэх нь” сэдэвт сургалтад 15 албан хаагч хамрагдлаа.

Аймгийн Улаан загалмайн хорооноос хүмүүнлэгийн тусламжийг тус сумын 2 иргэнд хүргэж 1.0 сая төгрөгийн өртөг бүхий эд зүйлийг гардуулж өглөө.

/COVID-19/ халдвараас урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэх ажилд 10 авто машин 68 м2, сумын төвд үйлчилгээ явуулдаг 12 цэгт 1702 м2, худаг уст цэг 20 м2,

түүхий эд хадгалах агуулах 1 цэгт 100 м<sup>2</sup> нийт 1890 талбайд ариутгал халдваргүйтгэлийн ажил хийлээ.

Тайлант сард орон нутгийн орлогоор хийгдэх ажлуудын тендерийг зарлаж Эрүүл мэндийн төвд техник тоног төхөөрөмж худалдан авах 20 сая төгрөгийн тендер шалгаруулж Экспресс оношлогооны төв шалгарч гэрээг байгуулан ажиллалаа.

Ноос, ноолуурын урамшуулал авсан 122 иргэний тайланг шивж баталгаажуулан, ногдлыг үүсгэж ажиллав.

2021 оны хаврын тариалалтаар 7 Аж ахуйн нэгж, 1 иргэн 6650 га талбайд улаан буудай тариалах ба үүнээс 400 га-д арвай, овьёос тариалалт хийх төлөвлөгөөтэй байна. Тариалалтад 601 тн үр шаардлагатай байгаа бөгөөд 2020 оны ургац хураалтаас 700 тн үр нөөцөлсөн ба 6 Аж ахуйн нэгж 1 иргэнд 601 тн үр дутагдалтай байна.

Сумын засаг даргын 2021 оны А/37 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг хамтран суманд архи, согтууруулах ундаа худалдан борлуулдаг түүгээр үйлчилдэг 12 аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалт ажлыг хийж гүйцэтгэлээ. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан.

Мал эмнэлгийн үйл ажиллагаанд хяналт тавих ажлын нэгдсэн удирдамжийн дагуу 2021 оны 03 дугаар сард малын эрүүл мэндийн гэрчилгээ олгох цахим системд 29 удаагийн гэрчилгээг цахимаар шивж гарган, иргэдэд хөнгөн шуурхай үйлчилгээ үзүүлэн ажиллалаа. Үүнд 28 адуу, 19 үхэр, 25 хонь, ямаа 8 гахай 2 толгой, адууны мах 100 кг, үхрийн мах 1390 кг, хонины мах 610 кг, үхрийн шир 19, хонины арьс 10 ширхэг, үхрийн толгой 3 ширхэг, тус бүр эрүүл мэндийн гэрчилгээ олгож хяналт тавин ажиллалаа.

Ойн мэргэжлийн байгууллагуудын 2020 оны мод бэлтгэлийн гүйцэтгэлд хяналт шалгалтыг 13 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэсэн. Дээрх хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны 01/112 тоот, мөн БОАЖГ-ын 2021 оны 115 тоот албан бичгийн дагуу арилгуулах сумын Засаг даргын 2021 оны А/28 тоот ажлын хэсэг байгуулах тухай захирамж гарч, ойн мэргэжлийн байгууллагуудад хугацаатай үүрэг чиглэл өгч ажиллалаа.

Мөн 2 аж ахуй нэгжийн 2021 онд мод бэлтгэсэн талбайн цэвэрлэгээг хүлээж авсан байна. Дээрх хугацаанд 19 аж ахуй нэгжийн 2021 онд мод бэлтгэх талбай тусгаарлалтыг 200 га талбайд хийж гүйцэтгэсэн.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын 2021 оны 18/02 тоот “Хяналт шалгалт хийх тухай” удирдамж, сумын Засаг даргын 2021 оны А/11 тоот “Ойгоос хэрэглээний болон түлээний мод бэлтгэлийн ажлыг зохион тухай” захирамжийн дагуу цагдаагийн хэсэгтэй хамтран төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2, төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 5 удаа хийж, нийт 8 иргэн, 21 аж ахуй нэгж хамрагдсан.

Хяналт шалгалтын явцад эзэн холбогдогч нь тодорхойгүй 64.8 м<sup>3</sup> нарсан гуалинг хураан авч цагдаагийн гадна төвлөрүүлэн ажилласан.

2020 оны мод бэлтгэлийн үйл ажиллагаа явуулсан талбайн ойн цэвэрлэгээг 2021 оны 03-р сарын 20-ны дотор байгаль хамгаалагчид төгсгөлийн актаар хүлээлгэн өгөх тухай АЛБАН МЭДЭГДЭЛ хүргүүлэн ажилласан. Үүний дагуу хангалтгүй цэвэрлэгээ хийсэн аж ахуй нэгжүүдэд хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллаж байна. Зөрчлийн тухай хуулийн 7.9-р зүйлийн 3 дахь заалтыг зөрчсөн “Шинэ Хүдэр Өгөөж” ХХК, “Хүдэр Очир” ХХК, “Тайгын Саарал” ХХК, “Хангайн буудай” ХХК-нд арга хэмжээ авч ажилласан.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх ГХУСАЗСЗ-өөс зохион байгуулсан “Архигүй орчин” хүүхдийн гар зургийн уралдаанд ирүүлсэн 70 зургаас 6 сурагч шалгарч өргөмжлөлөө гардуулан өглөө.

Иргэдийг соён гэгээрүүлэх, соёлын үйлчилгээ хүргэх зорилгоор соёлын төвөөс “ОУ-ын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”, “Цэргийн баяр”-ыг тохиолдуулан цахим концертыг зохион байгуулж ажилласан ба цахим орчинд 2103 иргэнд хүргэж ажиллалаа. Эмэгтэйчүүдийн баярыг угтан номын сангийн зүгээс Өвөрмөц нэгэн захидлын уралдааныг зохион байгуулан хүүхэд насанд 10а ангийн сурагч Б.Хатанзаяа, 7ё ангийн сурагч Ө.Эрхсаран, 7а ангийн сурагч М.Уран-Эрдэнэ нар видео хэлбэрээр 6б ангийн сурагч Ч.Уранцэцэг захидлаар тус тус хамрагдан тэргүүн байранд 10а ангийн сурагч Б.Хатанзаяа шалгарч өргөмжлөл, мөнгөн шагнал, дэд байранд 6б ангийн сурагч Ч.Уранцэцэг шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагналаа.

“Дэлхийн зөн Монгол” Олон Улсын байгууллагын Сэлэнгэ нэгдсэн хөтөлбөртэй “Төгсөлтийн аргачлал” төсөлд хамрагдсан 20 өрхийг чадавхжуулах, дэмжин ажиллаж санхүүжүүлэх төслийг өрх бүрээр гаргаж хүргүүлэв. Мөн коронавирусын халдварын үед хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх зорилгоор, амьжиргааны түвшингөөс доогуур орлоготой 135 өрхөд 100.0 төгрөгийн дэмжлэг үзүүлэх өрхийг судалгааг гарган хүргүүлж ажиллалаа.

### **Цагааннуур сум:**

Сумын Шуурхай штабт Засаг даргын Тамгын газрын албан хаагчид 24 цагийн ээлжээр ажиллан, цаг үеийн мэдээллийг иргэдэд хүргэн, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. “Бүдүүний гүүр”-ний постод 33, эргүүл хяналтад 16 төрийн албан хаагч, аж ахуйн нэгжийн ажилчид хамтран үүрэг гүйцэтгэж байна. Тус постоор орсон, гарсан тээвэр болоод иргэдийн тоон үзүүлэлт давхардсан тоогоор сум руу орсон 131 тээврийн хэрэгсэл, 349 иргэн, сумаас гарсан 441 тээврийн хэрэгсэл, 1235 иргэн байна. Өдөрт дунджаар 15 тээврийн хэрэгсэл, 45 иргэн сум руу орж, 20 тээврийн хэрэгсэл 56 иргэн сумаас гарч байна.

Улаанбаатар хот болон халдварын голомттой бүс нутгаас 205 иргэн ирж, 29 өрхөд, гэр бүлийн 59 гишүүдийн хамт тусгаарлагдсан байна. 45 байгууллагын 96500 м2 талбайд ариутгал халдваргүйтгэл хийж ажиллалаа.

Сумын Засаг даргын А/20, А/21 тоот захирамжаар Онцгой комисс болон Гамшгаас хамгаалах шуурхай штабыг шинэчлэн байгуулж шуурхай штаб, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний бэлтгэл бэлэн байдал, гал түймэр унтраах багаж хэрэгслийг шалгалаа.

Хичээл сургалтын үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбогдуулан Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг сургуулийн А,Б байр, 1,2 дугаар цэцэрлэгийн ариутгал халдваргүйтгэл, бэлтгэл ажилтай танилцаж үүрэг, чиглэл өгч ажиллалаа.

01-02-ны өдрүүдэд Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Төлөөлөгчид, Засаг даргын Тамгын газрын ажилтнууд, Эрүүл мэндийн төвийн эмч, ажилтнууд хамтран хөдөөгийн малчин 400 гаруй өрхөөр явж өвөлжилт, хаваржилт, мал төллөлт, хорогдлын байдалтай танилцан малчдын санал хүсэлтийг хүлээн авч малчдад цаг үеийн ажлын талаар мэдээлэл өгч, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж ажиллалаа.

Иргэдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх идэвх санаачлагыг сайжруулах зорилгоор “Хөршийн холбоог сайжруулж хүчирхийлэлгүй сум болъё” сарын нөлөөллийн аяныг өрнүүллээ. Уг ажлын хүрээнд иргэдэд хүүхдийн тусламжийн 108, гэмт хэрэг зөрчлийн мэдээ хүлээн авах 102, сумын мэдээлэл хүлээн авах шуурхай утсыг сурталчлан таниулж, постер гарын авлагыг тараан, иргэдэд хүчирхийлэлд өртдөг гэр бүлийн талаар мэдээлэх эрх үүргийг нь таниулах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Сэтгэцийн өвчтэй иргэдийн судалгааг гарган, “Тусалъя” төслийн хүрээнд явагдсан “Та үхэх талаар бодож байсан уу?” “Таны хүүхэд сэтгэцийн хувьд эрүүл бойжилттой юу?” сэдэвт шууд лайв подкастад 23 иргэнийг хамруулсан.

Сумын хэмжээнд эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн судалгааг гаргасан. Судалгаанаас үзэхэд 23 нь амьжиргааны баталгаажих төвшнөөс доогуур орлоготой өрхөд, 9 нь эцэг эхийнх нь аль нэг нь архины хамааралтай, 12 гэр бүлийн салалт, зөрчилтэй харилцаатай гэр бүлд амьдарч байна.

Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Мал эмнэлэг, үржлийн нэгжүүдтэй хамтран ил задгай хаясан 2 үхэр 1 адууны сэг зэмийг устгаж, бэлчээрийн 100 м2 талбайд хлорын шохойгоор мананцаржуулж халдваргүйжүүлсэн. 122 нохойг туулгалтад хамруулсан.

Сэлэнгэ бүсийн сум дундын Ойн ангитай хамтран Гүн Шүрэнд “Шинэ бадрах” ХХК-ий талбай тусгаарлалтыг шинэс модонд, Сангалтайд “Бүтээлийн нуур” ХХК-ий талбай тусгаарлалтыг шинэс модонд хийж гүйцэтгэлээ.

“Хоггүй цэвэрхэн Цагааннуур” аяны хүрээнд бүх нийтийн хог цэвэрлэгээний ажлыг 24-26-ны өдрүүдэд сумын хэмжээнд өрнүүлж ажиллалаа.

### **Шаамар сум:**

Монгол Улсын Засгийн газрын 45 дугаар тогтоол “Коронавируст халдвар /Ковид-19/ цар тархалтын төвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”, улсын Онцгой комиссын даргын 20 дугаар тушаал, 22 дугаар тушаал 7-р хуралдааны тэмдэглэл, аймгийн Онцгой комиссын 7 дугаар тогтоол, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллалаа.

Сумын хэмжээнд эргүүл хяналтыг 4 хүний бүрэлдэхүүнтэйгээр, шуурхай штабыг 24 цагаар, Шаамар 6, Дулаанхаан 4 замын хяналтын постыг тус тус ажиллуулж байна. Сумын хэмжээнд Улаанбаатар хот, Дархан-Уул аймгаас ирсэн нийт 18 тээврийн хэрэгсэлтэй 27 хүн ирснийг халдвар хамгааллын дэглэмийг баримтлан зөвлөмжийн баталгааны маягт бөглүүлэн нийт 18 өрхийн 26 том хүн 1 хүүхэд ирсэн, хамт байгаа өрхийн гишүүд 27 нийт 54 хүн гэрийн ажиглалтад байна.

Улсын Онцгой комиссын 22 тоот тушаалын дагуу сумын Засаг даргын А/20 захирамжаар Шуурхай штабыг шинэчлэн байгуулж ажиллах чиг үүргийг баталсан.

Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн оролцоог нэмэгдүүлэх нь”, “Сэтгэл хөдлөлөө удирдах нь”, “Харилцан хүндэтгэл, итгэлцэл бүхий орчинг бүрдүүлэх нь” сэдэвт 3 удаагийн сургалтад давхардсан тоогоор нийт 74 төрийн албан хаагчид хамрагдсан байна.

Коронавируст халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх тусгаарлах өрөөний эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг өөрийн хөрөнгөөр болон Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж, гэрээт байгууллагуудаасаа таталт хийсэн.

Гамшгаас хамгаалах бүлгийг Шуурхай штабын дарга зарлан дуудаж бие бүрэлдэхүүн, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг шалгаж үүрэг чиглэл өгч ажилласан. Сумын хэмжээнд иргэдээс ирсэн гомдлын дагуу нохой устгалын ажил эхлээд 80 хувьтай явагдаж байна. Мөн Сүхбаатар самбар, Шаамар 6 постын ойр

Сумын уяачдын холбооноос залуу уяач Б.Энх-Амгалан, Б.Азбаяр нарыг сумын Засаг даргын 2021 оны 03 сарын 17-ны өдрийн А/22, А/23 тоот захирамжаар Сумын алдарч уяач цол олгож үнэмлэх, залааг олгож ажилласан. Мөн “Хос бүүрэг” уяачдын холбооны уулзалт зохион байгуулж ажилласан.

Мал төллөлт бойжилтын мэдээ: /Төлийн мэдээ/ гүү 3, үнээ 533, эх хонь 650, эх ямаа 691 нийт 1877 төллөж хорогдсон төл тугал 4, хурга 11, ишиг 14, нийт 29 төл



хорогдсон. Том мал хорогдолын мэдээ: адуу 4, үхэр 11, хонь 15, ямаа 16 нийт 46 мал хорогдсон. Хорогдсон хээлтэгч: гүү 2, үнээ 5, эх хонь 9, эх ямаа 8 нийт 24 мал хорогдсон.

Сургууль, цэцэрлэгийн сургалтын үйл ажиллагаа 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхэлсэнтэй холбогдуулан Монгол Улсын Боловсрол, Шинжлэх ухааны сайдын 2021 оны “Ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагааг танхимаар зохион байгуулах тухай түр журам”-ийн дагуу сумын Засаг даргын 2021 оны А/16 тоот захирамжаар сургууль, цэцэрлэгийн орчмын бүсэд эрсдэлийн үнэлгээ хийх ажлын хэсгийг байгуулж Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмж бэлтгэх, цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйжүүлэлт, тэмдэглэгээ, зураглал байрлуулсан эсэх, тусгаарлах өрөөний бэлэн байдлыг хангасан эсэх, дотуур байранд мөрдөх халдвар хамгааллын дэгийг боловсруулсан эсэх, хүнсний бүтээгдэхүүний, хоол үйлдвэрлэлийн аюулгүй байдлыг хангасан эсэхэд хяналт тавьж, зөвлөмж өгч ажилласан.

Сумын худалдаа үйлчилгээ эрхлэгч 5 хүнсний дэлгүүрт 21 нас хүрээгүй хүнд архи, согтууруулах ундаа худалдан борлуулахгүй байх, оройны 22:00 цагаас өглөөний 10:00 цаг хүртэлх хугацаанд иргэдэд архи согтууруулах ундаа зарахгүй байх мөн 18 нас хүрээгүй хүүхдийг дэлгүүрт ажиллуулахгүй байх талаар зөвлөмж өгч ажиллалаа. Мөн эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 2 өрхөөр гэрээр очиж нөхцөл байдалтай танилцан, архи согтууруулах ундаанаас татгалзах талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

Сумын Засаг даргын Тамгын газар болон “Дэлхийн зөн Монгол” Олон Улсын байгууллагын Сэлэнгэ орон нутгийн хөгжлийн хөтөлбөрийн хамтын ажиллагааны хүрээнд “Төгсөлтийн аргачлал” төсөл хэрэгжиж эхэлсэн. Уг төслийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд төсөлд хамрагдсан 40 өрхөд 4 өдрийн “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Мөн Сэлэнгэ Орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй хамтран “Жендерийн эрх тэгш байдал”-ын талаарх сургалт зохион байгуулагдаж сумын Жендерийн эрх тэгш байдлыг хангах салбар хорооны гишүүд хамрагдлаа.

Иргэд олон нийтэд төрийн байгууллагаас зохион байгуулсан ажил арга хэмжээний талаарх мэдээ, мэдээллийг түргэн шуурхай хүргэх үүднээс сумын цахим хуудсаар дамжуулан 11 төрлийн сургалт сурталчилгаа, ажил арга хэмжээний талаарх мэдээ мэдээлэл, /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр 26 төрлийн мэдээ мэдээлэл, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 5 төрлийн мэдээ мэдээллийг цахим хуудсанд байршуулж ажиллалаа.

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН

ГАЗРЫН ДАРГА

Ө.СУВДАА

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:

МЭРГЭЖИЛТЭН

Д.АЛТАНТУЯА